

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "ШИНЭ ХӨГЖЛИЙН ЗАМ" ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.03.06

Булган аймаг

		Үүнээс																						
		Бүгд		1. Хүний хөгжлийн бодлого						2. Эдийн засгийн бодлого			3. Ногоон хөгжлийн бодлого				4. Засаглалын бодлого					5. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого		
				Бүгд	1.1. Эрүүл мэнд	1.2. Боловсрол	1.3. Биеийн тамир, спорт	1.4. Соёл, урлаг	1.5. Хөдөлмөр эрхлэлт	1.6. Нийгмийн хамгаалал, халамж	Бүгд	2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил	2.2. Хөдөө аж ахуй	2.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ	Бүгд	3.1. Байгаль орчин	3.2. Аялал жуулчлал	3.3. Уул уурхай	3.4. Дэд бүтцийн төлөвлөлт, төв суурингийн хөгжил	Бүгд	4.1. "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ		4.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ	4.3. Хууль, эрх зүй, батлан хамгаалах
Зорилтын тоо		103	29	8	5	4	6	3	3	22	6	12	4	22	7	3	3	9	20	2	7	11	10	
Үүнээс	"Үр дүнтэй" /100 хувь/	45	15	3	2	3	4	2	1	9	6	0	3	9	4	2	0	3	9	0	3	6	3	
	"Тодорхой үр дүнд хүрсэн" /70-100 хүртэл хувь/	52	14	5	3	1	2	1	2	10	0	9	1	11	3	1	3	4	10	2	4	4	7	
	"Эрчимжүүлэх шаардлагатай" /30-70 хүртэл хувь/	6	0	0	0	0	0	0	0	3	0	3	0	2	0	0	0	2	1	0	0	1	0	
	"Үр дүнгүй" /0-30 хүртэл хувь/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Хэрэгжүүлж эхлэх хугацаа болоогүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хувь		91.9	95.3	92.7	97.1	96.3	95.3	95.6	94.7	92.3	100	80.5	96.5	91.0	95.1	98.9	89.4	80.6	92.4	93.8	91.4	92.0	88.5	

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2024.03.06

Булган аймаг

№	Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
1.1. Эрүүл мэнд. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.			
1.1.1	Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Орхон сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг улсын төсвийн 2293.3 сая төгрөгийн хөрөнгөөр барьж 2023 онд ашиглалтад өгсөн бол Азийн хөгжлийн банкны 5600.0 сая, орон нутгийн төсвийн 602.0 сая төгрөгийн хөрөнгөөр Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн 15 ортой шинэ барилгын ажил 50.0 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2021 онд Бүрэгхангай, Орхон сумын эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсвийг орон нутгийн төсвийн 27.0 сая төгрөгөөр шинэчлэн хийлгэв. 2021 онд Гурванбулаг, Дашинчилэн, Орхон сумын моргийн барилгын зураг төсвийг орон нутгийн төсвийн 38.9 сая төгрөгөөр хийлгэж, 2022 онд Баяннуур сумын эрүүл мэндийн төвийн моргийн барилгыг орон нутгийн төсвийн 79.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан. 2023 онд Бугат, Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн моргийн барилгын ажлын зураг, төсөв хийгдэж, барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр 2024 оны улс, орон нутгийн төсөвт санал хүргүүлсэн. 2021 онд Гурванбулаг, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварыг улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгөөр, 2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт орон нутгийн төсвийн 218.0 сая төгрөгөөр их засвар, халдвартын тасгийн хуучин барилгад улс, орон нутгийн төсвийн 320.0 сая төгрөгөөр засвар хийж, "Нийгмийн эрүүл мэндийн төв" байгуулан улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт орон нутгийн төсвийн 171.0 сая, Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төвийн барилгад орон нутгийн төсвийн 14.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар урсгал засвар хийлээ. 2024 онд Бугат сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажилд орон нутгийн төсвийн 322.0 сая төгрөг, Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажилд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөг батлагдан, засварын ажил хийгдэж байна. 2021 онд улс, орон нутаг, хандив тусламжийн 3421.6 сая, 2022 онд 2010.4 сая, 2023 онд 613.9 сая, 2024 онд улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж, эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хангалтын хувийг нэмэгдүүллээ. 2021-2024 онд 36.0 сая төгрөгийн хөрөнгөөр 11 байгууллагад 70 камерыг суурилуулав. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг 2021 онд 52, 2022 онд 48, 2023 онд 24 төрлөөр тус тус нэмэгдүүлснээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалт 2021 онд 87.6 хувь, 2022 онд 89.5 хувь, 2023 онд 89.9, 2024 онд 90.2 хувьд хүрсэн.	77.5

1.1.2	Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмж, автомашинаар үе шаттай хангана.	2021 онд 16 сумын эрүүл мэндийн төвд ДЭМБ, улс, орон нутгийн төсвийн 139.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 23 нэр төрлийн, 2022 онд 4 сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 147.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 нэр төрлийн тоног төхөөрөмж, 2023 онд 4 сумын 8 багийн эмчийг орон нутгийн төсвийн 12.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, иж бүрдэл, 2024 онд 2 сумын эрүүл мэндийн төвийг улсын төсвийн 16.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангасан. Алслагдсан багийн иргэдэд хүргэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2021 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн 8.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эх барихын болон анхан шатны тусламжийн багцийг бүх багийн эмч нар, 2022 онд улс, орон нутгийн төсвийн 86.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 багийн эмчийг, 2024 онд улсын төсвийн 65.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 багийн эмчийг буюу нийт 15 багийн эмчийг "Mobile" тоног төхөөрөмжөөр хангалаа. 2021 онд улс, орон нутгийн төсвийн 118.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур, Гурванбулаг, Орхон сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт, 2022 онд улсын төсвийн 244.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хангал, Хишиг-Өндөр сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт, 2023 онд улсын төсвийн 315.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайхан, Тэшиг сумын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, 2024 онд улсын төсвийн 84.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 сумын эрүүл мэндийн төвийг тус тус яаралтай түргэн тусламжийн автомашинаар хангасан. 2021-2024 онд нийтдээ 15 эрүүл мэндийн байгууллагын автомашиныг шинэчлэхээр төлөвлөснөөс 11 эрүүл мэндийн байгууллагын автомашиныг шинэчилж, парк шинэчлэл 90.0 хувьтай болоод байна.	86.7
1.1.3	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	Хөдөөгийн иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 2021 онд 8 суманд зохион байгуулж, 3306 иргэн, 2022 онд 8 суманд зохион байгуулж, 3899 иргэнийг хамруулан өвчин, эмгэгтэй 1965 тохиолдлыг илрүүлэн, онош тодруулах, яаралтай эмчилгээнд хамруулахаар 263 иргэнийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Тус үзлэгийг 2023 онд 11 сум, 1 тосгонд зохион байгуулж, давхардсан тоогоор 16434 иргэнийг хамруулан, өвчин, эмгэгтэй 3722 тохиолдлыг илрүүлэн, онош тодруулах, яаралтай эмчилгээнд хамруулахаар 91 иргэнийг дээд шатлалын эмнэлэгт хүргүүлэв. 2024 онд дээрх үзлэг, шинжилгээгээр хүн амын дунд хоол боловсруулах замын өвчлөл, эмгэг ялангуяа хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчлөл илэрч байгааг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, эрүүлжүүлэх ажлыг эхлүүлээд байна. "Эрүүл шүд-эрүүл хүүхэд" арга хэмжээний хүрээнд 17 хүртэлх насны хүүхдүүдийн шүдний өвчлөлийг илрүүлэх үзлэгийг зохион байгуулж, 2021-2023 онд давхардсан тоогоор 2-17 насны 25029 хүүхдийг хамруулахад шүд цоорох өвчин 90 хувьд нь илэрч байгаа тул 2024 онд хүүхдийн шүд цоорох өвчнийг эмчлэн, эрүүлжүүлэх арга хэмжээг төр болон хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлж эхлээд байна. Аяны хүрээнд 2023 онд орон нутгийн төсвийн 4.4 сая төгрөгөөр Нэгдсэн эмнэлэгт зөөврийн бор машин, 37.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайхан суманд шүдний кабинет шинээр байгуулан мэргэжлийн эмчээр хангагдсанаар шүдний кабинет бүхий эрүүл мэндийн төвийн тоо нэмэгдэн, алслагдсан сумын иргэдэд шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх хүртээмж нэмэгдсэн. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 15-аас дээш насны 44714 иргэнээс 2021 онд 54.4 хувь, 2022 онд 55.3 хувь, 2023 онд 63.3 хувь нь хамрагдаж, сүүлийн 4 жилийн хугацаанд В вирусийн 46, С вирусийн 49 тохиолдлыг илрүүлэн, эмчилгээнд бүрэн хамруулсан.	100

1.1.4	Халдварт өвчний тандалт сэргийлэлтийг сайжруулж, эрт илрүүлэх, идэвхтэй үзлэгийг зохион байгуулж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг дээшлүүлнэ.	2021 онд "КОВИД-19" цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор "Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний тохиолдлын удирдлагын тогтолцооны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэн, улсын төсвийн 3054.2 сая, хандив тусламжийн 483.9 сая, орон нутгийн төсвийн 85.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цар тахалтай тэмцэх, сэргийлэх, хариу арга хэмжээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуураар хангагдсан. 2022 онд "КОВИД-19" цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулах зорилгоор Япон улсын Засгийн газрын 948.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл, 5 нэр төрлийн вирусийн эсрэг эм бэлдмэл, 3024 ширхэг ПГУ оношлуур, 1500 ширхэг түргэвчилсэн оношлуур, бусад эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг бэхжүүлсэн. Үүний үр дүнд шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлын хангалтыг нэмэгдүүлэн аймгийн хэмжээнд 3 сарын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлын нөөцийн хангалт 2021 онд 70.0 хувь, 2022 онд 84.0 хувь, 2023 онд 85.0 хувь, 2024 онд 85.0 хувьд хүрээд байна. Сүрьеэгийн халдварыг илрүүлж, халдварыг бууруулах зорилгоор илрүүлэг үзлэгийг төлөвлөн 2021 онд 8, 2022 онд 4, 2023 онд 15 суманд зохион байгуулж, сүрьеэгийн хавьтлын 3132 иргэнийг хамруулан, хавьтлын үзлэгийн хамрагдалтыг 2023 онд 80.2 хувьд хүргэсэн. БЗДХ/ХДХВ, тэмбүү илрүүлгийг сайжруулж, өвчлөлийг бууруулах зорилгоор зорилтот бүлгийн иргэдээс 2021 онд 26.9 хувь, 2022 онд 28.5 хувь, 2023 онд 24.0 хувийг хамруулснаар сүүлийн 3 жилд нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 78.5 хувьд хүргэж, илэрсэн тохиолдлыг 100 хувь эмчлэн эрүүлжүүллээ. Үүний үр дүнд аймгийн статистик үзүүлэлтээр хүн амын дунд бүртгэгдсэн халдварт өвчинд БЗДХ-ын эзлэх хувь 2020 онд 56.0 байсан нь 2023 онд 25.8 болж буураад байна. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн улирлыг угтуулан Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албатай хамтран томуугийн вакцинжуулалтыг зохион байгуулж, сүүлийн 3 жилд 2-5 насны болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 14660 хүүхдийг хамруулж, томуугийн халдвараас сэргийлэх арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.	100
1.1.5	Төрөлжсөн, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/381 дүгээр тушаалаар батлагдсан "Сувилахуйн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм"-ийн дагуу 2022 онд тус төвийг байгуулахад шаардлагатай судалгаа тооцоо хийгдэж, 2023 онд "Тусч шувуухай" нийгэмд үйлчилгээтэй төрийн бус байгууллага байгуулагдсан. Тус төвийн үйл ажиллагааг дэмжин орон нутгийн төсвийн 10.6 сая төгрөгөөр 7 төрлийн багаж, эмнэлгийн хэрэгслээр хангаж, сувилахуйн төвийг нээж, стандартын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилахуйн 11 төрлийн тусламж үйлчилгээг гэрээр 1351 иргэнд үзүүлж, тусламж үйлчилгээ авсан иргэдийн 23.5 хувь нь 4, 5 дугаар бүлгийн иргэд, 51.4 хувь нь ахмад настан, 17.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. 2023 онд улсын төсвийн 396.1 сая, орон нутгийн төсвийн 14.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 сумын эрүүл мэндийн төвийг суурин болон зөөврийн компьютероор ханган, эмнэл зүйн "E-Health" программ хангамж, сум, өрхийн эмч, сувилагч нар эрүүл мэндийн даатгалын цахим систем (http://health.gov.mn/), эмнэл зүйн систем ("Ehospital")-ийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглаж бүрэн цахимжсан.	100

1.1.6	Эрүүл мэндийн ажилтны чадавхыг сайжруулж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	2021-2024 онд үндсэн мэргэшлээр 15 эмч, төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр 13 эмч, 36 сувилагч, тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр 18 эмч, 6 сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн буюу нийт 46 эмч, 42 сувилагч, тусгай мэргэжилтэн сургаж бэлтгэснээр эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулан 2024 оны байдлаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн 80 хувь нь үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшлээр төгсөв. Сүүлийн 3 жилийн хугацаанд өндөр хөгжилтэй орны урт болон богино хугацааны сургалтад 11 их эмч, 11 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдаж, олон улсын түвшинд нэвтэрч байгаа эмчилгээ, оношилгооны орчин үеийн аргын талаар мэдлэгтэй болсон. 2021, 2023 онд Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн 24 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг амьдрах байраар ханган, байрны зардалд орон нутгаас 8.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Тэшиг суманд баригдсан төрийн албан хаагчдын байранд 1 сувилагч, Хялганат тосгонд баригдсан орон сууцанд 1 эмч, 1 сувилагчийг орон байраар хангав. Аймгийн хэмжээнд 202 сувилагч, 83 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд салбарын хүний нөөцийн хангалт 2021 онд 87.0 хувь, 2022 онд 87.5 хувь, 2023 онд 88.0 хувь, 2024 онд 88.5 хувьд хүрсэн. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль болон "Этүгэн" их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан ерөнхий мэргэжлийн болон туслах сувилагчаар тус тус 1 хүнийг элсүүлж, "Глобал удирдагч" сургуультай хамтран 19 сувилагчийг сургаж, хамтран ажиллах сургалтын хөтөлбөрийг эхлүүлээд байна. Мөн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Нүүр ам судлалын сургуультай хамтран шүдний туслах сувилагчаар 2, Эрүүл мэндийн яам, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Сувилахуйн сургуультай хамтран 6 туслах сувилагчийг төрийн сангийн санхүүжилтээр сургаж байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд 39 сувилагчийг мэргэшүүлэн шинээр бэлтгэж, орон нутгийн төсвөөс сургалтын төлбөрт 77.7 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.	97.5
1.1.7	Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өвчлөл, эндэгдлийг бууруулна.	2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх, эмэгтэйчүүдийн тасагт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэх төрөх өрөөг байгуулж, улсын төсвийн 55.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжөөр хангав. Мөн эхийн амрах байрыг 8.9 сая төгрөгөөр засварлан тохижуулж, алслагдсан сумаас ирсэн эхчүүд тав тухтай орчинд байрлаж, эмнэлгийн тусламж авах нөхцөлийг бүрдүүлсэн. 2023 онд хандив тусламж, орон нутгийн төсвийн 74.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн тоног төхөөрөмж, "Умайн хүүзүүний хорт хавдар"-ын эрт илрүүлэг, оношилгооны "CerviCare" AI системийг суурилуулж, 560 гаруй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг оношилгоонд хамруулав. 2024 оны байдлаар нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90.0 хувьтай байна. Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн чиглэлээр нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж сэдэвт онол болон дадлага хосолсон сургалтуудад 91 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. Сургалт, үйл ажиллагааны үр дүнд 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2021 онд 14.3, 2022 онд 22.1, 2023 онд 20.0 промилль болсон байна. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн өвчлөлийг бууруулах арга хэмжээний хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, 2021 онд 10661, 2022 онд 2123, 2023 онд 5737 эмэгтэйг хамруулснаар умайн хавдар, өндгөвчний уйланхай, цөсний чулуу зэрэг өвчлөлийн 233 тохиолдлыг илрүүлэн, 42 эмэгтэйг онош тодруулах, яаралтай эмчилгээнд хамруулахаар дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэн, эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар жирэмсний эрт үеийн хяналтыг 2021 онд 92.5 хувь, 2022 онд 92.1 хувь, 2023 онд 95.1 хувьд хүргэж, сүүлийн 4 жилд эхийн эндэгдэл гаргалгүй ажилласан.	90.0
1.1.8	Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.	Эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд 2021 онд Гурванбулаг, Сайхан сумын эрүүл мэндийн төв, 2023 онд Орхон сумын эрүүл мэндийн төв, 2024 онд Дашинчилэн сумын эрүүл мэндийн төв стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан. Ингэснээр аймгийн хэмжээний эрүүл мэндийн байгууллагуудын 95.0 хувь нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болоод байна.	90.0
1.2. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.			

1.2.1	<p>Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд сургах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.</p>	<p>Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд сургах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах олон талын арга хэмжээг зохион байгуулан 4338 суралцагч, 1500 гаруй эцэг эх, 371 багш, ажилтныг хамруулж 10.9 сая төгрөгийг зарцуулсан байна. "Шинэ Ирээдүй" хөтөлбөрийг 2 зорилт 13 дэд зорилтын 27 арга хэмжээтэйгээр төлөвлөн орон нутгийн төсвөөс 160.0 сая төгрөг зарцуулан 90.0 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд лектор болон ментор багш нар, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 90 гаруй сургалт, нөлөөллийн арга хэмжээ, гүйцэтгэл оношлох үнэлгээ зэрэг томоохон ажлуудад давхардсан тоогоор 28249 хүүхдийг хамруулав. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн 1620 сурагч, "Мэргэжил сонголт-Амжилтын үндэс" сургалт, өдөрлөгийг 2-9 дүгээр ангийн сурагч нарт 2-5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 8800 гаруй хүүхэд, 750 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна. Сургуульд бэлтгэгдсэн байдал, анги дэвших, төгсөх болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд 12-р ангийн 1800 гаруй сурагчийг хамруулан математикийн судлагдахуун суурь түвшнээс 5.1 хувиар, англи хэлний судлагдахуун 4.4 хувиар тус тус өсөж, хэмжээст онооны дунджаар улсын хэмжээнд 7 байр урагшлан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 77.4 хувь, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах цогц төлөвлөгөөний биелэлт 72.1 хувь буюу улсын дунджаас дээгүүр үнэлэгдлээ. Мөн 22 сургууль, 22 цэцэрлэг, 2 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны гадна, дотно орчны эрсдэлийн үнэлгээг жил тутам 2 удаа хийж, орчны эрсдэлийг 7 хувиар бууруулав. "Тогтвортой хөгжлийн боловсрол-2" төслийг 100 хувь хэрэгжүүлэн тус төсөлд хамрагдсан Булган сумын 2 дугаар сургууль "Эко орчин-Хүүхэд хөгжил", Хишиг-Өндөр сумын сургууль "Ногоон оффис", Хялганат тосгон "Эко камп", Могод сумын сургууль "Тогтвортой хөгжлийн боловсролын цахим сургалтын танхим" төсөлд 120.0 сая төгрөг зарцуулсан. Олон улсын эко сургууль, цэцэрлэг хөтөлбөрт ерөнхий боловсролын 9 сургууль, 9 цэцэрлэг хамрагдаж, 2 сургууль олон улсад зөвшөөрөгдсөн "Ногоон түг", 1 сургууль "Мөнгөн гэрэгэ", 3 сургууль, цэцэрлэг "Хүрэл гэрэгэ" хүртлээ. Нийт сургууль, цэцэрлэгийн 95.2 хувь нь туршилтын талбай байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүлэн 196 суралцагчид 861.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг, урамшуулал олгов. Үндэсний бичиг үсгийг түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийн хэрэглээ болгох зорилгоор сургалт, тэмцээн, уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 8622 багш, суралцагч, төрийн албан хаагчдыг хамруулж 10.2 сая төгрөг зарцуулсан.</p>	100
1.2.2	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.</p>	<p>БШУЯ-ны санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхимыг Булган сумын 1 дүгээр сургуульд байгуулж, тус танхимыг түшиглэн дохионы хэлний сургалтыг Булган сумын 1, 2, 3, Спортын дунд сургуулийн нийгмийн ажилтан болон 1 дүгээр сургуулийн багш, Насан туршийн боловсрол төвийн багш нарт зохион байгуулан, аймгийн боловсролын сургалтын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн 44 сурах бичиг, 44 гарын авлага, дохионы хэлний 22 багц картыг олгов. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 96 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа нь хамран сургалт суурь түвшнээс 33.3 хувиар, сургуулийн өмнөх боловсролд 21 хүүхэд буюу хамран сургалт суурь түвшнээс 29.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх зорилтын хүрээнд танхимын болон цахим 80 гаруй сургалтад давхардсан тоогоор 280 гаруй багш, удирдах ажилтнуудыг тогтмол хамруулан ажилласнаар аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшсэн багшийн тоо 82 болж суурь түвшнээс 78.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургуулийн өмнөх боловсролын багш нарыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх "Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих нь" сэдэвт сургалтад сургуулийн өмнөх болон бага боловсролын 30 гаруй багш хамрагдаж, "Жайка" олон улсын байгууллагын "Старт-2" хөтөлбөрийн тэгш хамруулах боловсролын хүрээнд цахим сургалтад 22 цэцэрлэгийн 135 багш, арга зүйч нар хамрагдан, цэцэрлэг бүрт дэмжлэгийн баг байгуулагдан үйл ажиллагааны хөтөлбөр, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p>	100

1.2.3	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжинэ.	<p>Боловсролын салбарт мэдээллийн технологи, цахим платформыг үе шаттайгаар нэвтрүүлэх, багш ажилчид, суралцагчдыг цахим орчинд ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлэхээр "Ubt.mn", "Амар сан"-гийн платформд цахим сорилго болон Боловсролын үнэлгээний төвийн жишиг даалгаврын сэдэвчилсэн сорилуудыг байршуулан "Welcome" хөтөлбөрт ахлах ангийн 24 сурагч суралцаж байна. Цахим хичээлийн medle.mn сайтад 61 хичээлийг байршуулан "Medle" цахим сургуультай хамтран ерөнхий боловсролын 20 сургуулийн 10-11 дүгээр ангийн сурагчдын сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулж байна. "After school" хичээлээс гадуурх үйл ажиллагааны цахим системийг нэвтрүүлэн ерөнхий боловсролын 20 сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын 2 байгууллагыг бүртгүүлэн танхимаар хичээллэх сонгон дугуйлан болон цахимаар суралцах хөтөлбөрүүдийг судлах боломжоор хангаж байна. Сургалтын хэрэглэгдэхүүний "Mlab" цахим платформд аймгийн хэмжээний 22 сургуулийн ашиглаж буй хичээлийн хэрэглэгдэхүүнийг 100 хувь бүртгэж оруулсан. Нийт судлагдахууны хэмжээнд 3000 орчим хэрэглэгдэхүүн ашиглагдах ёстойгоос аймгийн хэмжээнд 510 буюу 17.0 хувийг нь ашиглаж байна. Боловсролын ерөнхий газраас хэрэгжүүлж буй бага ангийн математик сургалтыг дэмжих "Eduten", англи хэлний сургалтыг дэмжих "Pearson" хөтөлбөрүүдийг цахим платформд суурилан зохион байгуулснаар шинээр 4 цахим платформ нэмэгдэж, цахим хичээлийн тоо 282 болсноор өмнөх оны мөн үеэс 84.0 хувиар ахисан. Насан туршийн боловсролын төв болон сумдын нэгжийн багш нар сургалтын 6 чиглэл, 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэн насан туршийн боловсрол олгох 2000 гаруй сургалтаар давхардсан тоогоор 76127 иргэн буюу зорилтот бүлгийн 90-ээс дээш хувийг хамрууллаа. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн 1620 сурагчид олгон, "Бие хүний хэв шинжийн тухай" Дж.Холландын оношилгоо тестэд 354 сурагчийг хамруулж, "Генетик тест Эрдэнэт" салбартай хамтран "Оюуны чадамжийг тодорхойлох дэлгэрэнгүй тайлан" генетик тестээр 11 хүүхдэд оношилгоо хийж, эцэг эхэд зөвлөгөө өгөв. Сур, суран эдлэлийн сургалтад хамрагдаж, сураар 4, 5, 6, 7, 8 гэсэн сүлжмэлийн төрлөөр сүлжиж өрхийн хэрэгцээнд хэрэглэж, багш, ажилтан, дунд ангийн сурагчдад уртын дуу, гийнгоо, морь, бөхийн цол зааж дуудах сургасан нь улсын хэмжээнд сайн туршлага болон түгсэн амжилттай байна.</p>	95.0
1.2.4	Багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарна.	<p>"Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт, 15 дэд зорилтын 22 арга хэмжээг хэрэгжүүлж, "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг хэрэгжүүлэн зорилтот 12 модулийн 315 төрлийн цахим болон танхимын сургалт, уулзалтад давхардсан тоогоор 66466 багш, удирдах ажилтныг хамруулан 206.1 сая төгрөг зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилт 91.0 хувьд хүрээд байна. Боловсролын ерөнхий газартай хамтран менежментийн загварыг туршин хэрэгжүүлснээр нийт сургуулийн 80 хувь нь сургууль хөгжүүлэх богино, дунд хугацааны төлөвлөгөөтэй ажиллан сургалтын чанар 14 хувиар өсөж, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлснээр байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ дунджаар 8.4 хувиар ахисан амжилт үзүүлээ. Судлагдахуун тус бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад 19 чиглэлээр 1875 багш, удирдах ажилтныг хамруулан багш нарын 90.0 хувь нь "Багш хөгжлийн төлөвлөгөө"-тэй ажиллаж, МУ-ын гавьяат багш 2, "Зөвлөх" зэрэгтэй багш 5, "Тэргүүлэх" зэрэгтэй багш 125-аар тус тус нэмэгдлээ. Үүний үр дүнд улсын илтгэлийн уралдаанд 6, 10 дугаар байр, Нийгмийн тухай мэдлэгийн улсын эсээ бичлэгийн уралдаанд 1 дүгээр байр, улсын төрөлжсөн олимпиадаас 4 багш медальт байранд шалгарсан амжилт үзүүлэв. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 79.7 хувь буюу суурь түвшнээс 7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Оросын шинжлэх ухаан, соёлын төвтэй хамтран орос хэл, соёлын хангайн бүсийн 5 аймгийн олимпиад, сургалт семинарыг зохион байгуулж, 48 сурагч, багшийг хамруулав. Мөн математикийн масс олимпиадыг 2024-2025 оны хичээлийн жилд буюу 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	95.0

1.2.5	Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Тайлант хугацаанд Гурванбулаг сумын цэцэрлэгийн барилгыг улсын төсвийн 1003.9 сая, Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг 1278.5 сая, Хангал сумын цэцэрлэгийн барилгыг "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын 1276.0 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус барьж ашиглалтад оруулав. Баян-Агт сумын 320 хүүхдийн хичээлийн байр, Хутаг-Өндөр сумын цэцэрлэг, Булган сумын 4 дүгээр цэцэрлэг, Дашинчилэн сумын 150 хүүхдийн дотуур байр улсын төсвийн 3412.6 сая, Хутаг-Өндөр сумын 150 хүүхдийн дотуур байр улсын төсвийн 3189.1 сая төгрөгөөр тус тус баригдаж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 30-70 хувьтай үргэлжилж байна. Рашаант сумын цэцэрлэгийн барилга, Сайхан сумын 320 хүүхдийн хичээлийн байр улсын төсвийн 5078.8 сая, Хялганат тосгоны 150 хүүхдийн дотуур байрыг улсын төсвийн 3343.3 сая төгрөгөөр тус тус барихаар тендер шалгаруулалт зарлаад байна. Тэшиг сумын спорт заалны барилгыг улсын төсвийн 566.5 сая төгрөгөөр барьж 2022 онд ашиглалтад оруулж, Могод сумын спорт заалыг улсын төсвийн 1250.0 сая, Бугат сумын спорт заалыг улсын төсвийн 1000.0 сая төгрөгөөр тус тус барьж эхэллээ. Булган сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны их засварыг улсын төсвийн 276.2 сая, Могод сумын ЕБС-ийн дотуур байрны их засварыг 269.9 сая, Булган сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварыг орон нутгийн төсвийн 400.0 сая, Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн барилгын их засварыг "Өвсний үндэс" хөтөлбөрийн 388.0 сая, Дашинчилэн сумын цэцэрлэгийн их засварыг 300.0 сая төгрөгөөр тус тус хийж ашиглалтад оруулан сургалт үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн. Орхон 230.0 сая, Сэлэнгэ 250.0 сая, Гурванбулаг 388.0 сая, Дашинчилэн 200.0 сая, Бүрэгхангай 700.0 сая, Хангал 200.0 сая, Хишиг-Өндөр сум 98.0 сая төгрөгөөр тус тус сургуулийн их засварыг хийлгэлээ. Баяннуур сумын спорт заалны дээврийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 75.9 сая төгрөгөөр, Рашаант сумын спорт заалны их засварыг 92.0 сая төгрөгөөр гүйцэтгэн 2023 онд ашиглалтад оруулав. 2021-2024 онд аймгийн хэмжээнд 51 гэр цэцэрлэгтэй болж, суурь түвшнээс 22.4 хувиар өсөж, гэр цэцэрлэгт 800 гаруй хүүхэд сургалт, үйл ажиллагаанд хамрагдаж байна. Боловсролын салбарт шаардлагатай тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн улс, орон нутгийн төсвийн 2318.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	95.6
1.3. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвөл, зуны спортуудыг дэмжиж, Булган аймгийн баг, тамирчдын улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.			
1.3.1	Хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл дадал хэвшилд сургах, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд шаардлагатай фитнесийн 23 төрлийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 27.4 сая төгрөгөөр, Биеийн тамир, спортын газрын А зааланд үзэгчдийн 400 ширхэг сандал авч, усан бассейны усны тоос сорогч, ус цэвэршүүлэгч, үсрэлтийн тавцанг шинэчиллээ. Усан спорт сургалтын төв болон фитнес клубын хэрэглэл материалыг нэмэгдүүлснээр иргэдийн спортоор хичээллэх орчин нөхцөл сайжирч хичээллэгсдийн тоо 900-д хүрч суурь түвшинтэй хариуцуулахад 25.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өсвөрийн шигшээ багийн сэргээлтийн баазыг барьж байгуулахаар Бугат сумын нутаг Өвөлжөөн булагт 2 га газарт хашаа барьсан. Мөн Биеийн тамир, спортын газрын "Б" заалны иж бүрэн засварыг 2023 онд орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн санхүүжилтээр "ЭПО" ХХК хийж гүйцэтгэв.	85.0
1.3.2	Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, олимпын төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, тамирчдын амжилтыг ахиулах, олон улс, улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээн зохион байгуулж, аймгийн өсвөрийн шигшээ багийг 12-оос доошгүй төрлөөр байгуулна.	Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор үндэсний спортын холбоодуудтай хамтран ажиллаж, тэмцээн уралдаанд 160.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Аймгийн өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилт, хэрэглэл материал, тэмцээний зардалд орон нутгийн төсвөөс 80.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж улс, бүсийн чанартай 31 удаагийн уралдаан, тэмцээнд өсвөрийн шигшээ багийн 278 тамирчин оролцож, 207 медаль хүртэж, үзүүлсэн амжилт суурь түвшинтэй харьцуулахад 2 дахин өссөн байна. Өсвөрийн шигшээ багийг спортын 12 төрлөөр хичээллүүлж байгаа бөгөөд мэргэжлийн 12 багш, дасгалжуулагч бэлтгэл, сургуулилтыг удирдан зохион байгуулж байна. 2021-2023 онд олон улс, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарч аймгийн хэмжээнд журмын болзол хангасан 393 тамирчин, 59 дасгалжуулагчид 105.4 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон	100

1.3.3	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын шаардлага хангасан талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ.	Орон нутгийн төсвийн 2570.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулагдсан гадаа талбайг Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр суманд байгуулж, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газартай хамтран ажиллах гэрээний хүрээнд 94.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Нано брилант" ХХК Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуульд 30х60 хэмжээтэй хөл бөмбөгийн талбай байгуулан 100 метрийн гүйлтийн замыг ашиглалтад оруулсан. Мөн иргэдийн эрүүл мэнд, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэн Булган суманд 2490х3 хэмжээтэй явган хүний болон дугуйн зам, МСҮТ-ийн хажууд 30х60 хэмжээтэй нийтийн биеийн тамирын талбай, 520х25 хэмжээтэй эрүүл мэндийн замыг ашиглалтад орууллаа. 2021-2024 онд спортын салбарын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт суурь түвшинтэй харьцуулахад 3.4 дахин нэмэгдсэн байна.	100
1.3.4	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, гадаад харилцааг бэхжүүлнэ.	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх 2021-2023 оны төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн төсвөөс 290.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 34 арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүллээ. Гадаад орнуудтай хамтын ажиллагааг сайжруулах, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 48.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Беларусь улсын Могилев мужид тамирчдын хамтарсан бэлтгэл сургуулилт хийж, Бүгд Найрамдах Беларусь улсын гавьяат дасгалжуулагч Г.Т.Ривкиний нэрэмжит боксын нээлттэй тэмцээнд оролцоход 20.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгаас 7 тамирчин оролцож 4 хүрэл, 1 мөнгө, 1 алтан медаль, БНХАУ-д Азийн наадамд оролцсон Олон улсын хэмжээний мастер Ц.Баттулга F-40 ангиллын бөөрөнцөг түлхэлтийн төрөлд оролцож II байр, Азийн наадамд хүрэл медаль хүртсэн амжилтыг тус тус үзүүлж Франц улсын Парис хотод зохион байгуулагдах Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан. Улс, бүсийн чанартай 4 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулан орон нутгийн төсвөөс 121.1 сая төгрөг зарцуулав.	100
1.4.Соёл, урлаг. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний өв уламжлалыг залгамжилж, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагатай хослуулан хөгжүүлнэ.			
1.4.1	Анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх замаар соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангана.	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 88.1 сая төгрөгийн санхүүжилтээр 23 төрлийн контент бэлтгэн олон нийтэд хүргэв. Булганы соёл урлагийн өдөр арга хэмжээний хүрээнд 2021-2022 онд аймгийн Хөгжимт жүжгийн театр, Орхон аймгийн "Эрдэнэт" дуу бүжгийн чуулгын дуучдын "Монголоо дууля" концерт болон Олон улсын бүжигчдийн өдөрт зориулан "Урлан бүжихүй" бүжгийн бүрэн хэмжээний хамтарсан тоглолтыг зохион байгуулж, тоглолтод 58 уран бүтээлч оролцон 2.0 сая төгрөг зарцуулан хоёр аймгийн иргэдэд 4 удаа толилуулан, 1500 гаруй үзэгчдэд хүргэсэн. Соёл урлагийн үзвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэн ажилласнаар үйлчлүүлэгчдийн тоо суурь түвшнээс 41.6 хувиар нэмэгдсэн байна. Ардын урлаг, соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах зорилгоор 2021-2022 онд "Булган хангай" хүүхдийн урлагийн наадмыг Соёл урлагийн их сургууль, Монгол улсын Консерватортой хамтран зохион байгуулж, 13.6 сая төгрөгийн санхүүжилтээр 4 насны ангилалд 12 төрлөөр явуулж, 1211 хүүхэд оролцон, авьяас ур чадвараа сорин өрсөлдлөө. 2023 онд орон нутгийн төсвийн 9.5 сая төгрөгөөр "Булган хангай" ардын урлаг, өв соёлын наадмыг Хөгжимт жүжгийн театр, Монголын урчуудын эвлэлийн Булган аймаг дахь салбар хороотой хамтран зохион байгуулав. Тус уралдаанд 12 сум, 1 тосгоны 100 гаруй авьяастнууд 12 төрлөөр оролцож, соёлын бүтээлч үйлдвэрлэл, гар урлалын төрлийг нэмэгдүүлснээр үйлдвэрлэл эрхлэгчид, урчуудыг дэмжин идэвхжүүлсэн онцлогтой ажил болсон. Соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор аймгийн "Бүх нийтийн соёлын боловсрол олгох 2021-2023 оны төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлэв. Соёл урлагийн үзвэр үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд бүх нийтийн соёлын боловсрол олгох чиглэлээр 36 арга хэмжээ төлөвлөж, 349 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 184723 иргэнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 98.2 сая төгрөг зарцуулсан. Шинээр 26 уран бүтээлийг сэргээн туурвиж, музей, орон нутаг судлах кабинетыг 85 шинэ үзмэрээр баяжуулан ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100

1.4.2	Аймгийн соёлын төвүүдийн барилгыг үе шаттай засварлан, салбарын материаллаг баазыг сайжруулна.	Баруун замын байлдааны штаб музейн их засварыг 2021-2022 онд 117.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Онъ тэнгэрийн бичиг" ХХК хийж гүйцэтгэн улсын төсвийн 41.9 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Музей, Баруун замын байлдааны штаб музейг камержуулж, дохиолол хамгаалалтын системийг шинэчилсэн. Рашаант, Хишиг-Өндөр сумын соёлын төв, Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн барилгын засварыг орон нутгийн төсвийн 225.0 сая төгрөгөөр, Баяннуур сумын соёлын төвийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 199.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Тэшиг сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас 15.0 сая төгрөгөөр, Сэлэнгэ сумын соёлын төвийн дээврийн засварыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Сайхан сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэлээ. Булган сумын Соёлын ордны их засварын ажлыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгөөр, аймгийн Музейн барилгын их засварын ажлыг орон нутгийн төсвийн 120.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлж 2024 онд үлдэгдэл 200.0 сая төгрөгийг шийдвэрлэн засварын ажлыг эхлүүлээд байна. 2023 онд Бугат сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын 200.0 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэн 2024 оны улсын төсөвт 1648.8 сая төгрөг, Бүрэгхангай сумын Соёлын төвийн барилгын зураг төсвийг орон нутгийн хөгжлийн сангийн 22.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн 2024 оны улсын төсөвт 3831.9 сая төгрөгийг тус тус батлуулсан. Соёл урлагийн байгууллагын техник хэрэгсэл, материалыг үе шаттай шинэчлэх зорилгоор улс, орон нутгийн төсвийн 890.6 сая төгрөгөөр материаллаг баазыг нэмэгдүүлэв. Ингэснээр соёлын байгууллагуудын техник тоног төхөөрөмжийн хангалт 90.0 хувьд хүрч, иргэд олон нийтэд соёлын үйлчилгээг чанартай, саадгүй хүргэх нөхцөл боломж бүрдсэн.	86.7
1.4.3	Аймгийн соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлж, урлаг, соёл, аялал жуулчлалын "Эвент" үйл ажиллагааг зохион байгуулна.	2024 онд Булган аймагт "Алтаргана-2024" наадмыг зохион байгуулах эрхийг авч, Алтаргана наадмын бэлтгэл ажлын хүрээнд "Дангина-Гоо бүсгүй", "Бидний Гоёл" хувцас загвар зохион бүтээгч, загвар өмсөгч шалгаруулах уралдаан, "Лого" бүтээх уралдаан, "Уран сайхны гэрэл зураг"-ийн уралдаан зэрэг арга хэмжээг улсын хэмжээнд нээлттэй зарлаж, шилдэг бүтээлүүдийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Мөн "Буриад дуу бүжиг"-ийн уралдаанд 16 сум, 1 тосгоны 460 гаруй авьяастнууд оролцож, шалгарсан оролцогчид "Алтаргана-2024" Олон улсын наадамд аймгаа төлөөлөн оролцох эрхээ авч бэлтгэлээ хангаж байна. "Алтаргана 2024" наадмыг зохион байгуулах хорооны анхдугаар хуралдааныг хийж Оросын холбооны Улсын болон аймаг, орон нутгийн 100 гаруй зочид төлөөлөгчид оролцон наадмын ерөнхий удирдамж батлах, тов тогтоох асуудлаар хэлэлцүүлэг явуулан баталлаа. Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 200.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Айраг, адууны соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 207.0 сая төгрөгөөр "Айраг наадам" эвент арга хэмжээг зохион байгууллаа. Наадмын хүрээнд 8 төрлийн /дэмбээ, айраг хэн сайн уух вэ, эмнэг сургах, шагай харваа, буриад сурын харваа, хос морьтон, хамгийн сайхан айраг, сайхан айрагны хөхүүр, 64 бөхийн барилдаан/ тэмцээн уралдаан зохион байгуулж, аймгийн 13 сумын 600 гаруй иргэд оролцож соёл, урлагийн эвент үзвэр үйлчилгээг давхардсан тоогоор 42 мянга гаруй иргэнд хүргэв.	100

1.4.4	Орон нутгийн соёлын байгууллагууд, иргэн, ААНБ, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийг хамгаалалтад авах, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлнэ.	2021 онд аймгийн "Соёлын өв тээгчид"-ийн анхдугаар чуулганыг цахимаар зохион байгуулж, аймгийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон ярилцаж, соёлын бүтээлч үйлдвэрлэл инновацийг хэрхэн нэвтрүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Аймгийн хэмжээнд 192 өвлөн уламжлагч бүртгэлтэй байдгаас тус чуулганд 123 өв тээгч оролцсон. 2022 онд Булган сумын хэмжээнд шилдэг 8 өвлөн уламжлагчийг журмын дагуу сонгож, аймгийн Хөгжимт жүжгийн театрт тайлбарт концерт тоглож, 16 өвлөн уламжлагчийг улсын төсвийн 527.0 мянган төгрөгийн дурсгалын зүйл, орон нутгийн төсвийн 3.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулав. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулахаар 2021-2022 онд түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого, судалгааг аймгийн хэмжээнд 92.0 хувьтай явуулж, улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас 33 дурсгалыг орон нутгийн хүмүүстэй хамтран ажиллах гэрээ байгуулан эзэнжүүлэн хамгаалалттай болгов. Мөн Дашинчилэн сумын "Цогтын цагаан байшин"-ыг орон нутгийн төсвөөс 79.0 сая төгрөгөөр санхүүжүүлэн хашаалж, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт "Хүйс толгойн бичээс" бүхий гэрэлт хөшөөг залах ёслолыг Могод суманд зохион байгуулав. "Ингэт толгой"-н түүх дурсгалын дэвсгэр зургийг үйлдэх, хүн чулуун хөшөөг баримтжуулах туршилт судалгааны ажил хийгдэж, улсын төсвийн 41.9 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Музей, баруун замын байлдааны штаб музейг камержуулж, дохиолол хамгаалалтын системийг шинэчилсэн. Аймгийн нутагт дэвсгэрт байгаа соёлын өвүүдийг гадаад, дотоодын жуулчдад сурталчлах зорилгоор 2021-2022 онд соёлын аялал жуулчлалын маршрут бий болгож, цахим орчинд "Булганаар аялагчид" нийтийн бүлэг үүсгэн аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг сурталчилж байна. 2023 онд орон нутгийн төсвийн 77.3 сая төгрөгөөр "Монголын баялаг-330" төсөлтэй хамтран аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүхэн дурсгалт газрууд, соёлын биет болон биет бус өвийг бүртгэн баримтжуулж, архивлах ажлыг зохион байгуулж, 17 контент бэлтгүүлэн сурталчлах ажлыг зохион байгуулав. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт суурь түвшинтэй харьцуулахад 63.6 хувиар өссөн байна.	100
1.4.5	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ.	Улсын хэмжээнд зохион байгуулсан "Авто-рали" уралдааны нээлтийг Цогтын цагаан байшин орчим газарт зохион байгуулж, жуулчдад зориулсан түүхийн дурсгалт газруудын гарын авлагыг 300 хүнд тараан сурталчилж, "Цогт тайжийн цагаан байшин"-ийн хашаажуулалт, хамгаалалтыг чангатгах, сурталчилан таниулах ажилд 106.8 сая төгрөг зарцуулав. Мөн Дашинчилэн сумын Хар бухын музейд дэвэр, дотор засалт, хашааны их засварын ажлыг Дашинчилэн сумын нутгийн зөвлөлийн хандив тусламжийн 12.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулж, "Цогтын цагаан байшин", "Хар бухын балгас" түүх дурсгалын газруудыг гадаад, дотоодын 500 жуулчин ирж, үзэж сонирхсон. Баруун замын байлдааны штаб музейн их засварыг 2021-2022 онд 117.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Онъ тэнгэрийн бичиг" ХХК хийж гүйцэтгэв. 2023 онд аймгийн нутаг дэвсгэрт байгаа соёлын өвүүдийг гадаад, дотоодын жуулчдад сурталчлах зорилгоор аялал жуулчлалын маршрутыг бий болгон Булган сумын Соёлын ордны цахим хуудсанд байршуулж, аяллын өртөө байгуулан танин мэдэхүй, хөгжөөнт тэмцээн уралдааныг зохион байгуулж, Булган сумын Соёлын ордны дэргэдэх дугуйлангийн 120 гаруй хүүхэд, 400 гаруй жуулчдыг хамруулав.	85.0
1.4.6	Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэж, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого баримтална.	2021-2022 онд Монгол Улсын Консерваторитай хамтран элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 25 хүүхдэд элсэн суралцах урилга гардуулсан. "Булган хангайн хүүхдүүд 2022" урлагийн наадамд оролцсон төгсөх ангийн шилдэг 5 сурагчид МУ-ын Консерваторт 100 хувийн тэтгэлэгтэй суралцах эрх олгов. Соёл Урлагийн Их сургуулиас зохион байгуулсан 5 багц сургалт, Соёл урлагийн газраас зохион байгуулсан 6 чиглэлийн сургалт, Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан 12 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 320 ажилтан, албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. 2023 онд Соёл урлагийн их сургууль, Сити их сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 10 хүүхдийн сургалтын төлбөрт орон нутгийн төсвийн 35.5 сая төгрөгийн санхүүжилтээр дэмжлэг үзүүлэв. Аймгийн соёл урлагийн салбарт ажиллаж байгаа 174 ажилтнаас 65.5 хувь буюу 114 нь мэргэжлийн ажилтан байна. Соёлын байгууллагуудад ажиллаж буй мэргэжлийн бус 61 ажилтнаас 8 ажилтныг СУИС-д эчнээгээр сурахад дэмжлэг үзүүлсэн. Соёлын салбарын мэргэжилтэй хүний нөөцийн хангалт суурь түвшинтэй харьцуулахад 2023-2024 онд 70.0 хувь болж өмнөх оноос 15.8 пунктээр нэмэгдсэн байна.	100
1.5.Хөдөлмөр эрхлэлт. Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.			

1.5.1	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн суурь судалгааг "Бүргэд" төрийн бус байгууллагатай 10.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж, зорилтот нэгжийн 93.1 хувийг судалгаанд хамруулан, дүгнэлтийг албан хэрэгцээнд ашиглаж байна. 2021-2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, иргэд, албан байгууллагууд руу чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэн, хөдөлмөр эрхлээгүй 2753 иргэнийг ажлын байранд зуучилснаас байнгын ажлын байранд 1298, улирлын ажлын байранд 403, түр ажлын байранд 1052 иргэнийг зуучилж, ажилгүйдлийн түвшнийг бууруулав. 2021 оны суурь үзүүлэлтээр манай аймгийн нийт хүн амын 63.5 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 62.2 хувь байсан бол тайлант хугацаанд хөдөлмөрийн насны хүн ам 3.5 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 63.9 хувьд хүрч суурь үзүүлэлтээс 1.7 пунктээр тус тус өслөө. Хүн амын нийгмийн хамгааллын болон иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааны нийтлэг асуудлаар "Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022, 2023-2024 оны хэлэлцээр"-ийг байгуулж, гэрээний хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон цалин хөлсний үзлэг шалгалт, сумдын салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж, 165 гишүүнийг хамруулсны зэрэгцээ үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагаас түүвэрлэн 13 төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа 177 аж ахуйн нэгжид цалин хөлсний үзлэгийг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооноос "Нийгмийн түншлэл 2021-2022", "Хөдөлмөрлөх эрх, тулгамдсан асуудал, шийдлийн гарц", "Үйлдвэрчин ба оролцоо" сэдэвт хэлэлцүүлэг уулзалтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ажилласны дүнд 2021 оны хэлэлцээрийг 75.0, 2022 оны хэлэлцээрийг 93.0, 2023 оны хэлэлцээрийг 94.0 хувьтай тус тус хэрэгжүүлэв. Жил бүрийн 4 дүгээр сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн ажиллаж, байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллагсдын мэдлэг, мэдээлэл 50.0 хувиар дээшилсэн үзүүлэлттэй байна.	86.7
1.5.2	"Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, багш, суралцагсдын ажиллах, сурах орчин нөхцөлийг сайжруулж, МСҮТ-үүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар шийдвэрлэнэ.	2021-2024 онд Булган аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд 53 мэргэжлийн багш ажиллаж, 30 гаруй мэргэжлээр сургалт явуулж, сүүлийн 4 жилийн байдлаар 1300 гаруй мэргэжлийн үнэмлэхтэй ажилтан бэлтгэн гаргасны 62 хувь нь ажилд орж, тогтмол орлоготой болжээ. 2023 оноос гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, мэргэшүүлэх болон туршлага судлах сургалтуудыг зохион байгуулж, ОХУ-ын Эрхүү мужийн Байкальскийкийн үйлдвэрлэл үйлчилгээний техникум, Эрхүүгийн авто тээвэр, замын барилгын коллеж, Барилга архитектурын техникум түүний Шелехов хотын салбар сургууль, БНХАУ, Японы OISCA олон улсын байгууллагатай байгуулсан санамж бичгийн хүрээнд барилгын засал чимэглэл, гагнуурчин, органик тариалалт, бусад мэргэжлийн чиглэлээр 18 багш, 1 оюутан туршлага судлах сургалтад, 8 багш, 1 оюутан мэргэжил дээшлүүлэх гадаад сургалтад тус тус хамрагдсан нь багшлах хүний нөөцийн 89 хувийг эзэлж, чадавхжуулах сургалтад хамрагдсан багшийн тоо өмнөх оноос 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний сургалтад 125 залууг хамруулж, 38 залуу мэргэжилтэй ажилтан байнгын ажлын байраар хангагдсан. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн МСҮТ "Багшийн хөгжлийн төв"-ийг шинээр байгуулж ашиглалтад оруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банкны хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд хүнсний ногооны фермер, хүлэмжийн аж ахуйн фермер, малын асаргаа мэргэжлүүдийн онолын танхим, лабораторийн барилга болон 8x20 харьцаатай өвлийн хүлэмжийг сэргээн засварлаж, 67 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 273.6 сая төгрөгийн санхүүжилтээр авч хичээл сургалт, дадлагын үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр оюутан сурагчдын сурах орчин нөхцөл бүрэн шинэчлэгдэж, орчин үеийн стандартад нийцсэн техник тоног төхөөрөмжөөр хангагдав. Япон улсын "Өвсний үндэс" төслөөс "Булган хангай" МСҮТ-ийн үйлдвэрлэлийн дадлагын орчныг сайжруулах их засварын ажлыг 2024 онд 860.0 сая төгрөгөөр эхлүүлэхээр гэрээ байгууллаа.	100

1.5.3	<p>Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэдийг дэмжиж зээлэнд хамруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болгоно.</p>	<p>Хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зорилгоор "Булганд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг 2018 оноос "Дэвшилт" ХХК-ийн байранд, 2022 оноос Хутаг-Өндөр суманд шинээр байгуулан ажиллуулж, жил бүр 90-95 иргэний 110 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, 2021-2024 онд 23.7 сая төгрөгийн борлуулалт хийж, ашгийг иргэдэд буцаан олгосон. Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлах үзэсгэлэн худалдааг жил бүр 3-аас доошгүй удаа зохион байгуулж, иргэдийг худалдан авалтаар дэмжиж байна. 2021-2023 онд давхардсан тоогоор 3645 ажлын байрны захиалга авч, ажил хөдөлмөр зуучлах үйлчилгээг албан ёсны вэб сайт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй сурталчлан ажилласны үр дүнд 2753 иргэнийг ажилд зуучилсан. Эдгээр иргэдийн 1298 буюу 47.1 хувь нь байнгын, 14.9 хувь нь улирлын, 38.0 хувь нь түр ажлын байранд зуучлуулсан байна. Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шинээр 4274 шинэ ажлын байр бий болсны 990 нь байнгын ажлын байр, 889 нь улирлын ажлын байр, 2395 нь түр ажлын байр байна. 2024 онд 1300 ажлын байрыг шинээр бүртгэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 249 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, ажлын байраа өргөтгөхөд нь зориулж 2.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн сахүүжилтээр 114 өрхийг 6021 тоо толгой малаар малжуулж, нэг өрхийн малын тоо толгойг 30-40 хувиар нэмэгдүүлсэн. Туслах аж ахуйг дэмжих төслийн хүрээнд 2021, 2023 онд 9 өрхөд гахай, тахиа, зөгийн аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэн 47.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, өрхийн орлогыг нэмэгдүүлэв.</p>	100
<p>1.6.Нийгмийн хамгаалал. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жендэрийн тэгш байдлыг хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.</p>			
1.6.1	<p>Аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангана.</p>	<p>Зорилтот өрхийн хөгжлийг дэмжих “Зөв гэр бүл” хөтөлбөрт 4 жилийн хугацаанд 326 өрхийг сонгон авч хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, байнгын орлоготой болгох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулав. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, жижиг зээл, малжуулах төсөл, эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнүүдэд 57 өрхийн иргэдийг хамруулан 135.0 сая төгрөг зарцуулсан. Эдгээр ажлын үр дүнд зорилтот өрхийн 68 хувь буюу 221 өрхийн амьжиргаа дээшилж, амьжиргааны зайлшгүй хэрэглээнээс доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувь 18.4 болсон нь суурь түвшнээс 1.6 пунктээр буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоог хангах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний эрхийг хамгаалах зорилгоор 2021-2024 онд орон нутгийн төсөөс хөтөлбөрийн зардалд 28.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, төлөвлөгдсөн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг жил бүр 24 удаа зохион байгуулж, жилд дунджаар 180 гаруй хүүхдийн асуудлыг хэлэлцэн, 205-238 хүүхдэд асаргаа тогтоосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт сүүлийн 3 жилийн хугацаанд 59 иргэн хамрагдаж, 336.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, ажлын байраа хадгаллаа. “Ахмадын өргөө”-ний барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлэн, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээ, мэдээллээр хангах төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ уралдаан тэмцээн, дэмжлэг тусламжид 152.1 сая төгрөгийг зарцуулан “Ахмад настны хөгжил, хамгааллыг сайжруулах жилийн ажлын төлөвлөгөө”-г 90.5 хувьтай хэрэгжүүлэв. Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 4 зорилтын хүрээнд 20-23 ажлыг төлөвлөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх залуучуудын хөгжлийн төвөөс сумдын залуучуудын салбар зөвлөл, залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг мэргэжил, арга зүй, үйл ажиллагааны чиглэлээр ханган 2020-2024 он хүртэлх хугацаанд дунджаар 98.0 хувьтай хэрэгжүүлэв. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлээс хамгаалахад байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор байгууллагуудын дэргэдэх 68 эцэг эхийн зөвлөлийг байгуулан чадавхжуулах ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх ажлуудын үр дүнд 2024 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн тоо суурь түвшнээс 52.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	91.7

1.6.2	Хүн амын бүлгүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах зорилгоор хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тэдний ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Булган суманд улсын төсвийн 1245.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Ахмадын өргөө"-ний барилгыг барьж 2021 онд ашиглалтад оруулсан бөгөөд "Ахмадын өргөө"-г түшиглэн "Хөгжлийн төв"-ийг байгуулж, тус төвөөр үйлчлүүлж буй иргэдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэхээр 2021-2024 онд 6.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхим байгуулагдан насан туршийн боловсрол хариуцсан багш сургуулийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд Австрали улсын элчин сайдын яамны бичил төслийн 18.0 мянган Австрали долларын хөрөнгө оруулалтаар Булган суманд шинээр түр хамгаалах байр барьж, 2022 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар халаалт, сантехникийн холболтыг хийж, барилгын ажил бүрэн дууссан. 2022 онд Азийн хөгжлийн банкны "Хүүхэд хүчирхийллийг бууруулах" төсөл 5.0 мянган долларын санхүүжилтээр үйлчлүүлэгчийн өрөө, гал тогооны тавилга хэрэгсэл, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 7.5 сая төгрөгийн санхүүжилтээр сургалтын өрөө, хүүхдүүдээс мэдүүлэг авах өрөөг тохижуулсан. Мөн түр хамгаалах байрны дэргэд Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн 55.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 улирлын хүлэмж байгуулж, мөн сангийн буцалтгүй тусламжаар түр хамгаалах байранд амьдрах ухааны сургалт явуулахад шаардлагатай хэрэглэл материалыг нэмэгдүүлэв. Түр хамгаалах байр нь нэг дор 12 хүртэл тооны үйлчлүүлэгч хүлээн авах боломжтой бөгөөд ажиллах хүчний зардлыг улсын төсөвт, түр хамгаалах байранд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах саналыг 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулав. "Жаргалант" зуслангийн гал тогоо, хоолны заал, сургалтын танхим бүхий захиргаа удирдлагын байрны барилгын ажлыг улсын төсвийн 920.0 сая төгрөг, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын 307.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 220.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эко эрдэнэс үүр" ХХК гүйцэтгэн, барилгын ажил 2023 онд бүрэн дууссан. Мөн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2 дахь шатлалын хөрөнгө оруулалт 60 хүүхдийн "Жаргалант" хотхоны 1.6 тэрбум төгрөгийн барилгын ажлын саналыг 2024 оны улсын төсөвт тусгуулан зуслангийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 4 хотхон, ерөнхий дэд бүтэц, орчны тохижилтын зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж байна.	92.5
1.6.3	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.	Аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2021 онд 89.2 хувь, 2022 онд орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр 4 зорилтын хүрээнд 21 ажил төлөвлөж, төлөвлөгөөний биелэлт 90.3 хувь, 2023 онд 4 зорилтын хүрээнд 23 ажлыг төлөвлөн 92.0 хувьтай гүйцэтгэсэн. Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн талаарх ойлголт өгөх сургалт нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 2021 онд 4845 иргэнд хүрч ажиллан орон нутгийн төсвөөс 1.6 сая төгрөг, 2022 онд 2243 иргэнд хүрч ажиллан орон нутгийн төсвөөс 2.5 сая төгрөг, 2023 онд 3273 иргэнд хүрч ажиллан орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг зарцуулсан. Үүний үр дүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд хүргэж, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчилсөн байна.	100
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, иргэдийн амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэгч аймгийн нэг болно.			
2.1.1	2.1.1. Эдийн засгийн хөгжлийн 2021-2024 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.	2020 онд ДНБ 399.4 тэрбум төгрөгт хүрсэн нь урьдчилан тооцоолсон дүнгээс 6.3 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бөгөөд нэг хүнд ноогдох ДНБ 6.5 сая төгрөгт хүрсэн байна. Жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн газрууд 6584.5.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 8439.3 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 13.7 хувиар, борлуулалт 8.7 хувиар тус тус өссөн байна. Нийт үйлдвэрлэлтийн 55.9 хувийг боловсруулах аж үйлдвэр, 40.3 хувийг дулаан түгээлт, усан хангамжийн үйлдвэрлэл эзэлж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 55.6 хувийг хөдөө аж ахуй, 19.2 хувийг үйлдвэрлэл, 25.2 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны гүйцэтгэлээр 485.8 тэрбум, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 7.8 сая төгрөгт хүрч дотоодын нийт бүтээгдэхүүн 21.6 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 12.1 хувиар тус тус өссөн байна. Үүнээс хөдөө аж ахуйн салбар 35.9 хувийн өсөлттэй гарлаа. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 онд 549.8 тэрбум төгрөгт хүрч, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8.8 сая төгрөгт хүрсэн байна. 2023 онд ДНБ 586.6 тэрбум төгрөг, нэг хүнд ноогдох ДНБ 9.5 сая төгрөгт хүрсэн. Аймгийн ДНБ-ийг 2020 онтой харьцуулахад 187.2 тэрбум, нэг хүнд ноогдох ДНБ 2.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.	100

2.1.2	Эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоод хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг тогтвортой нэмэгдүүлж, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Аймгийн аялал жуулчлалын форум, уул уурхайн зөвлөлдөх уулзалт, тариаланчдын зөвлөгөөнүүдийг зохион байгуулж, аймгийн эдийн засгийн өсөлтийг дэмжиж сайжруулахаар салбарын бодлого зорилтуудаа тодорхойлсон. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны Улаанбаатар хотод "Булганчууд-2021" арга хэмжээг төр, хувийн хэвшлийн байгууллагууд болон гадаадын Элчин сайдын яамд, олон улсын төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын хүрээнд амжилттай зохион байгуулсан. 2023 онд "Хөдөөгийн сэргэлт-хөрөнгө оруулагчдын чуулган"-ы бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, аймгийн Засаг дарга, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, агентлагийн дарга нар болон 16 сум, 1 тосгоны удирдах бүрэлдэхүүн зэрэг шийдвэр гаргах түвшний олон талын оролцоотой 101 хүн оролцлоо. Энэ үеэр 16 сумын Засаг дарга, 1 тосгоны Захирагч нар сум, тосгоныхоо товч танилцуулгыг хийж, өөрийн орон нутагтаа хэрэгжүүлж болохуйц аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын боломжийн талаар дурдсан. Аймгийн онцлог буюу тулгуур салбар бол хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал юм. Хөдөөгийн сэргэлт хөрөнгө оруулагчдын чуулганыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, 200 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан орон нутагт хөрөнгө оруулалт хийх боломжийг танилцуулж, харилцан санал солилцсон. Аймгийн хэмжээнд 2020-2023 онд улс, орон нутаг, дотоод, гадаадын 200 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.	100
2.1.3	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	2021-2023 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 38.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 236 төсөл хэмжээнээс 59 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 7.9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Энэ нь тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 20.3 хувийг эзэлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу дотоодын давуу эрхийг 5 төсөл арга хэмжээнд 8 нэр төрлийн бараанд 176.8 сая төгрөгөөр тооцуулсан. Аймгийн Засаг даргын 2021 оны А/22 захирамжаар орон нутгийнхаа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах, ажлын байрыг хадгалж үлдэх, санхүүгийн эрсдэлээс сэргийлэхэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх чиглэлийн дагуу төр, төсвийн байгууллагууд хэрэгцээт бараа ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулж, 2021 онд 1130.8 сая төгрөг, 2022 онд 1779.8 сая төгрөг, 2023 онд 2253.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	100
2.1.4	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.	Татварын цахим тайлангийн системээр татвар төлөгчдийг бүртгэх, тайлан хүлээн авах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх бүх төрлийн татварын үйлчилгээг цахимаар үзүүлж ажилласнаар хуулийн этгээдийн тоо 2017 болж суурь түвшнээс 6.6 хувь, татвар төлөгч иргэний тоо 45436 болж суурь түвшнээс 14.6 хувиар өсөж, татварын бааз суурь нэмэгдсэн байна. Аймгийн татварын баазад бүртгэлтэй татвар төлөгчдийг 4 түвшинд ангилан, ангилал тус бүрт тохирсон сургалт, сурталчилгааны төлөвлөгөө гарган тайлант хугацаанд 513 удаагийн сургалтад давхардсан тоогоор 18504 татвар төлөгчийг хамруулан татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэв. Татварын ногдол, тайлагнал, хураалтын үйл ажиллагаа 100 хувь цахимжсанаар татвар төлөх 14 төрлийн сувагтай болж, 2021-2023 онд улсын төсөвт 6.0 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 126.6-129.1 хувь, аймгийн төсөвт 76.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 104.0-125.3 хувь, орон нутгийн төсвийн орлогод 33.8 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.1-105.3 хувиар тус тус биелүүллээ. 2021-2023 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 29 татвар төлөгчид 342.3 сая төгрөгийн хөнгөлөлт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу давхардсан тоогоор 2329 иргэний 1495.2 сая төгрөгийн хөнгөлөлтийг тус тус буцаан олгосон.	100
2.1.5	Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.	Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан Сангийн яамны Төрийн сангийн газраас "Төрийн сангийн удирдлагын цахим систем", "Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-ийг бүрэн нэвтрүүлэв. Төрийн сангийн удирдлагын цахим системээр аймаг, сумын 156 төсөвт байгууллага төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэж байна. Эрхийн бүртгэлийн сан, төрийн сангийн удирдлагын цахим системийн холболт, тохиргоог төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах 1180 төрийн сангийн дансанд хийж, цахим шилжилттэй холбоотой сургалтад сумдын санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогчдыг хамруулж, 4 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 1140 албан хаагч хамрагдсан. Цахим шилжилттэй холбоотой цахим сургалтыг тухай бүр Сангийн яамтай хамтран зохион байгуулж, модуль бүрээр бэлтгэсэн видео хичээлийг байршуулж, мэдээлэл хүргэсэн.	100

2.1.6	Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлангийн цахим санд бүртгэлтэй 1388 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн бөгөөд 2020 оноос 9.9 хувиар буюу 138 аж ахуйн нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. 2020-2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ирц 92.0-94.0 хувьтай, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн ирц 85.5 хувийн гүйцэтгэлтэйгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд нэгтгэгдсэн. Санхүүгийн тайлангийн цахим и-баланс систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын захирал, нягтлан бодогч нарт цахим болон танхимын сургалт зохион байгуулж, мэдээллээр тухай бүр ханган жилийн эцсийн санхүүгийн тайлан хүлээн авах бэлтгэл ажлыг хангав. Санхүүгийн тайланг хянаж баталгаажуулах явцад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу алдаатай тайланг залруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өссөн дүнгээр 577 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, нягтлан бодогчид буюу нийт байгууллагын 42 хувьд өгсөн. Санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй 11 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцон 7400.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Төсвийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар журам, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажилласнаар 2020-2023 онд нийт зарлагын гүйцэтгэл дунджаар 61.7 тэрбум төгрөг буюу 87.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020-2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан "Зөрчилгүй" санал дүгнэлт авч, төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэв.	100
2.2.Хөдөө аж ахуй. Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.			
2.2.1	Хөдөө аж ахуйн салбарын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.	Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн, малчид, тариаланчдыг чадавхжуулах, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, 655 тариаланч, малчдын зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулан 2290 малчныг хамруулж, ОХУ-ын Буриад улсын Хөдөө аж ахуйн их сургуульд 13 мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, төрийн бус байгууллагуудтай хамтран давхардсан тоогоор 621 мэргэжилтэн, албан хаагчийг үе шаттай сургалтуудад хамруулж, чадавхжуулсан байна. Орхон сумын Халиун багт мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний төв байгуулахаар 0.5 га газрыг сумын ИТХ-ын тогтоолоор олгож, зураг төсвийг боловсрууллаа. Аймгийн Мал эмнэлгийн газарт орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариутгал халдваргүйтгэлийн ДУК автомашин, орон нутгийн төсвийн 166.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Хутаг-Өндөр суманд мал эмнэлгийн 4 зөөврийн хашаа, малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар 16 сумын 50 багт 50 үзлэг ангилалтын зөөврийн хашааг засварлаж, ашиглалтад оруулснаар зөөврийн хашааны хангалт аймгийн хэмжээнд 50.0 хувьд хүрлээ. Мөн "Шинэ хөдөө" төслийн 440.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 суманд 40 ширхэг мал угаалгын ванныг нийлүүлэв.	73.3
2.2.2	"Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг сайжруулна.	Улсын төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 207 толгой хээлтүүлэгч, малчид болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 64 толгой бухыг сумдад нийлүүлснээр цэвэр үүлдрийн үхэр сүргийн нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ 22.5 хувьд хүрсэн. Улсын төсвийн 51.6 сая төгрөгөөр баяд үүлдрийн 250 толгой хуцыг Сайхан суманд, Бүрэгхангай сумын баяд хонины суурь, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Ренчинлхүмбэ, Увс аймгийн Зүүнговь сумаас үржлийн нэгж болон малчдын түвшинд 182.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баяд үүлдрийн 1253 хуц, дархад үүлдрийн 730 хуцыг шилэн сонгож, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Сайхан, Орхон суманд нийлүүлснээр хээлтүүлэгч малын дутагдлыг багасгаж, баталгаажсан үүлдэр омог буюу өндөр ашиг шимт малын тоог 24.4 хувьд хүргэж, гарсан үр төлийн чанар сайжирч, амьдын жин 1-2 кг-аар нэмэгдсэн үр дүнд хүрлээ. Ямааны ашиг шим, ноолуурын гарц, чанарыг сайжруулахаар улсын төсвийн 15.0 сая төгрөгөөр 50 ухныг авч Сайхан сумын "Их уялага" мал эмнэлэг, үржлийн нэгжид нийлүүлсэн. Баян-Агт суманд үйл ажиллагаа явуулдаг "Агтын шилмэл сүрэг" мал үржлийн нэгжид малчдын 75.0 сая төгрөгөөр Эрчмийн хар үүлдрийн 50 ухна, малчдын хотонд 450, "Хужрын адаг" ХХК мал үржлийн нэгжээс малчдын хотонд Эрчмийн хар үүлдрийн 20 хээлтүүлэгчийг нийлүүлснээр хээлтүүлэгч малын дутагдлыг багасгаж, баталгаажсан үүлдэр омог буюу өндөр ашиг шимт малын тоог 24.4 хувьд хүргэж гарсан үр төлийн чанар сайжирч, ноолуурын гарц нэмэгдсэн.	66.0

2.2.3	"Чинээлэг малчин" дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, дотоодод мал, махны худалдааг нэмэгдүүлэн экспортод гаргаж, малчдын орлогыг өсгөнө.	"Чинээлэг малчин" хөтөлбөрийг "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөртэй уялдуулж хөдөө аж ахуйн салбарт 3.5 тэрбум төгрөгийн 5 нэр төрлийн тоног төхөөрөмж, бараа нийлүүлсэн. Тухайлбал: эрчимжсэн аж ахуй эрхлэгч 9 өрхөд 140 зөгийн бүл, 2 суманд 608 толгой шилмэл сүрэг, 10 суманд цэвэр үүлдрийн 64 бух, 9 суманд хадлангийн иж бүрэн техник тоног төхөөрөмж, мал угаалгын 40 ширхэг ванныг тус тус нийлүүлэв. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVIII дугаар хуралдаанд танилцуулж, 83.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. Хөтөлбөр хэрэгжсэнээр өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ 4.4 хувиар, бог малын амьдын жин 1-2 кг-аар, үхэр сүргийн амьдын жин 20-25 кг-аар нэмэгдэж, малчид жилдээ 300-400 толгой үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч худалдан борлуулж 500-700 сая төгрөгийн борлуулалт хийж, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг 1.1 тэрбум төгрөгийн зээл, тусламжид хамруулж, үйл ажиллагааг нь дэмжиж байна. Аймгийн хэмжээнд 1702 бух, 8164 хуц, 4163 ухна дутагдалтай байснаас 354 бух, 1983 хуц, 570 ухныг нөхөн тавьж, дутагдаж буй хээлтүүлэгчийн тоог 20 хувиар бууруулж, үүлдэрлэг байдал сайжирч, ашиг шим дунджаар үхэр сүргийн амьдын жин 20-25 кг-аар, бог малын амьдын жин 1-2 кг-аар нэмэгдсэн үр дүнтэй байна.	95.0
2.2.4	Мал аж ахуй эрхлэлтийг дэмжих, өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувийг 25-д хүргэнэ.	2022 оны жилийн эцсийн мал тооллогоор өндөр ашиг шимтэй 879.6 мянган мал тоологдсон ба 2023 онд 26.7 мянга буюу 1.9 хувиар нэмэгдэж, 906.3 мянгад хүрч нийт сүрэгт эзлэх өндөр ашиг шимтэй малын тоо 24.4 хувьд хүрлээ. 2021 онд Бугат, Булган, Могод, Сэлэнгэ сумын "Сум хөгжүүлэх сан"-аас шинээр эрчимжсэн аж ахуй эрхлэх 13 төсөлд 104.0 сая төгрөг, 2022 онд "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан"-аас гахайн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр Булган сумын "Энхжин хүнс" ХХК 100.0 сая төгрөг, Орхон сумын "Булган Милк" ХХК хоршоо хөгжүүлэх сангаас 70.0 сая төгрөг, Тэшиг сумын "Тэшиг агро" ХХК махны чиглэлийн 275 үхэр, Сэлэнгэ суманд 1 иргэн сүүний чиглэлийн "Алатау" үүлдрийн үхэр, Булган сумын 1 иргэн сүүний чиглэлийн үхрийн аж ахуй байгуулахаар нийт 577.5 сая төгрөгийн зээлд хамрагдаад байна. 2023 онд "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан"-ийн хөнгөлөлттэй зээлд махны чиглэлийн үхэр үржүүлэхээр Сэлэнгэ сумын "Цотан тал" ХХК, Тэшиг сумын "Залман Хангай" ХХК, Хутаг-Өндөр сумын "Гурт Брийдинг" ХХК, махны чиглэлийн хонь үржүүлэхээр Сэлэнгэ сумын "Эко Органик Ингэт" ХХК, сүүний үхэр үржүүлэхээр Бугат сумын "Бугат Агро" ХХК нийт 460.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд 19 иргэн, аж ахуйн нэгж эрчимжсэн аж ахуйн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байна. "Шинэ хөдөө Булган" дэд хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ сумын 5 өрхөд 60 бүл зөгий, Хутаг-Өндөр сумын 4 өрхөд 80 бүл зөгий, нийт 140 бүл зөгийг гэрээ байгуулан олгож, үйл ажиллагааг дэмжив. Хишиг-Өндөр сумын "Дархан хаан Молор" ХХК малын тэжээлийн үйлдвэр байгуулж, 90-100 га талбайд тариалалт хийж, 40-50 тн тэжээл, Бүрэгхангай сумын "Бодь алтай хийц" ХХК хоногт 15 тоннын хүчин чадал бүхий багсармал тэжээлийн үйлдвэр байгуулж, 100 тн тэжээл тус тус үйлдвэрлэж байна. Аймгийн хэмжээнд тэжээлийн ургамал тариалалт 6682 га талбайд хүрч, жилдээ 15-20 мянган тн тэжээл хураан авч байна.	83.3
2.2.5	Хадлан, бэлчээрийн талбайг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уст цэгийн хайгуул судалгаа хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.	Баяннуур сумын Бор булангийн хадлангийн талбайг сэргээх 300.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтад "Усны барилга" ХХК шалгарч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай гэрээ байгуулан ажлаа эхлүүлсэн. Гэрээнд ажлыг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр тусгасан байна. Улсын төсвийн 350.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Могод, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Хангал суманд хадлангийн иж бүрэн 9 тоног төхөөрөмж, улсын төсвийн 223.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 90 морины хүчин чадал бүхий хадлангийн иж бүрэн тракторыг Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Хишиг-Өндөр суманд тус тус олгов. Аймгийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 3.6 сая толгой мал тоологдож, нийт малын тоо өмнөх оноос 270 мянга (6%)-аар буурлаа. Малын тоо толгойг бэлчээрийн даац багтаамжид нийцүүлэхээр жил бүр нийт малын 26.0 хувьтай тэнцэх 1.2 сая гаруй толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж байна. Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа "Доройтсон бэлчээрийг зайнаас тандах аргаар судалж, сайжруулах туршилт судалгааны төв"-ийг түшиглэн Гурванбулаг сумын 11 га талбайд бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээрийн 8 сорт таримлыг нутагшуулах үзүүлэх сургалт, Дашинчилэн суманд үр үржүүлэх сургалтыг зохион байгуулж, Баяннуур, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр сумын 33 малчныг хамруулж, 1075 кг үр олгосон. Улс, орон нутгийн төсөв, малчдын 972.0 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн хэмжээнд 63 худаг гаргаж, бэлчээрийн усан хангамжийг 88 мянган га талбайгаар нэмэгдүүлсэн. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 худаг гаргахаар төсөвт тусгагдсан.	90.0

2.2.6	Малын гоц халдварт, халдварт өвчний эрсдэл бүхий бүс нутагт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулна.	Тайлант хугацаанд жил бүр улс, орон нутгийн 1.0-1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариун цэвэр, халдваргүйтгэл, тандалт шинжилгээний ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мал эмнэлгийн газарт ариутгалын ДУК автомашин авч, вакцин хадгалах хөргүүрийн засварын ажилд 24.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв. Аймгийн хэмжээнд тайлант онуудад гарсан гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах, бог малын мялзан өвчний тархалтыг зогсоох, устгах зорилгоор 7 удаагийн арга хэмжээнд 106.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, халдварт өвчний тархалтыг 36.3 хувиар буурууллаа. Жил бүр орон нутгийн төсвийн 600-700 сая төгрөг, улсын төсвийн 200-300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.2-1.3 сая толгой мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулснаар өвчний тархалт 36.3 хувиар буурч, нийт өвчлөлийн 0.1 хувийг эзэлж байна. Мал, амьтны халдварт бруцеллэз өвчний халдварын түвшнийг илрүүлэх, эрүүлжүүлэх шинжилгээнд 21.9 мянган хээлтүүлэгч мал хамруулах төлөвлөгөө батлуулж, 16 сумын 49 багийн 59 суурийн 275 бух, 8522 хуц, 4499 ухна буюу нийт 13.2 мянган хээлтүүлэгчийг хамруулж, 60.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Тандалт шинжилгээний дүнгээр аймгийн хэмжээнд 12 хуц, 6 ухна эерэг дүн үзүүлснийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлж, шинжилгээний дүнг баталгаажуулсан. Аймгийн дүнгээр бруцеллэз өвчний халдварлалтын түвшин өмнөх оноос 0.04 хувиар буурч, нийт өвчлөлийн 0.8 хувийг эзэлж байна. Адууны ям өвчний тандалт шинжилгээнд 6 сумыг сонгон 2000 адууг хамруулахаас 1689 адууг хамруулахад халдварлалт илрээгүй. Мөн сүрьеэ өвчний тандалт шинжилгээнд 8 сумын 2000 үхэр хамруулахаар төлөвлөн 1080 үхрийг хамруулж, шинжилгээний дүнгээр эрүүл байна. Сүүлийн 3 жилд хийсэн тандалт, шинжилгээний дүнгээр аймгийн хэмжээнд үхрийн сүрьеэ, лейкоз, адууны ям өвчний тохиолдол бүртгэгдээгүй эрүүл бүсээр тогтоогдсон.	96.7
2.2.7	Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицидийн үлдэгдэл тодорхойлж, малын эмийн зохистой хэрэглээг хангана.	"Малын эмийн үлдэгдлийг хянах" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн 2021-2023 оны ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллав. Лабораторийн шинжилгээний итгэмжлэлийн хүрээг өргөтгөх зорилгоор малын мах, сүү, өндөг, малын тэжээлд MNS 6665-2017 стандартын дагуу эмийн үлдэгдлийн шинжилгээ хийх эрхийг Үндэсний итгэмжлэлийн төвийн 2021 оны А/124 дүгээр тушаалаар баталгаажуулсан. Улсын төсвийн 4.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сүүнд антибиотекийн үлдэгдэл тодорхойлох оношлуур болон бусад хэрэглэгдэхүүнийг нийлүүлсэн. Аймгийн хэмжээнд 54.1 тн мах, 14.3 тн сүү, сүүн бүтээгдэхүүнийг баталгаажуулсан. Үүнээс лаборатори шинжилгээнд мах, сүүний 335 сорьцод 12 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэнээс 90.7 хувь буюу 304 сорьцод 3 үзүүлэлтээр эмийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээ хийхэд антибиотек болон ивэрмектиний үлдэгдэл илрээгүй.	90.0
2.2.8	Атрын IV аяныг орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.	Дашинчилэн сумын "Өрхтий трейд" ХХК, "Мүкү" ХХК 2670 га талбай, Хишиг-Өндөр сумын "Дархан хаан молор" ХХК 197 га, Хужиртын ногооны газар 6.2 га, Жимс жимсгэний плантаз 6.7 га, Баяннуур сумын иргэн Б.Түвшинжаргал 100 га талбай, Сэлэнгэ сумын 16 аж ахуйн нэгжийн 4090.3 га талбай, Бугат сумын 3 аж ахуйн нэгжийн 2050 га талбай, Бүрэгхангай сумын 2 аж ахуйн нэгжийн 340 га талбай, Хангал сумын 2 аж ахуйн нэгж 2160 га талбай, Тэшиг сумын 12 аж ахуйн нэгж, иргэн 6100 га талбай, Сэлэнгэ сум 1769 га талбай, Бүрэгхангай сум 1000 га, Булган сум 17.7 га, Хутаг-Өндөр сум 4550 га, нийт 25056.9 га талбайг агрохимийн шинжилгээнд хамруулсан. Хутаг-Өндөр сумын "Улаанбуудайн эх газар" ХХК, Сэлэнгэ сумын "ИНТОСЭ" ХХК, "Оргилдэлгэрэх" ХХК, Хангал сумын "Молор-Эрдэнэ түрүү" ХХК, Орхон сумын "Орхон бодь" ХХК Дархан-Уул аймгийн Эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран нутагшсан сортын үр үржүүлэхээр туршилтын тариалалт хийж, нэгжээс 11-28 цн ургац хураан авчээ. Сэлэнгэ суманд тэжээлийн ургамлын үр үржүүлгийн чиглэлээр "Ингэттолгой" ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 онд 150 га талбайд царгас тариалж хамгаалалтын хашаа барьж, 833 га талбайгаас 1600 тонн ногоон тэжээл хураан авсан. Аймгийн хэмжээнд 13.1 км тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулаад байна. Тухайлбал: Хутаг-Өндөр сум 2.1 км газарт 500 ширхэг шар хуайс, 3000 ширхэг хайлаас, 1000 ширхэг улиас, Булган сум 2.2 км газарт 11070 ширхэг бургас, хайлаас модыг 2 үеэр, Хишиг-Өндөр сум 1.5 км газарт 1000 ширхэг бургас, Бүрэгхангай сум 1.5 км газарт 800 ширхэг бургас тус тус тариалсан.	86.7

2.2.9	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, аймгийн хүн амын хүнсний ногооны хэрэгцээг 50- иас доошгүй хувиар хангана.	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд хэрэгжиж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслөөс орчны бүсийн сумдын иргэдийн өрхийн амьжиргааг дэмжих зорилго бүхий "Хүнсний ногооны нэмүү өртгийг дэмжих нь" дэд төсөлд Сэлэнгэ сумын 17 өрхийн 64 иргэн хамрагдаж, трактор дагалдах агергатууд, Бугат сумын "Найрамдал Бугат" хоршоонд "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийн хүрээнд 40 морины хүчин чадалтай төмс, хүнсний ногоо тариалах иж бүрэн төхөөрөмж, орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө Булган" төслийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 50-90 морины хүчин чадал бүхий 11 тракторыг дагалдах иж бүрдлийн хамтаар 10 суманд олгож ашиглалтыг сайжруулав. ХХААХҮЯ-аас 80.0 хувийн хөнгөлөлттэй үнээр ирсэн 13 төрлийн 2571.4 кг /бөөрөнхий сонгино төл үр 2000 кг, сармисны үр 500 кг, бусад ногооны үр 71.4 кг/ хүнсний ногооны үрийг 16 сум, 1 тосгонд хуваарилж, тариалалт хийсэн. Мөн Дархан-Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй гэрээ байгуулж, элит гала сортын төмсний 5 тн үрийг 3 ногоочинд нийлүүлж, үрийн шинэчлэлт хийлээ. 2023 онд төмс 473 га талбайд тариалж 3.3 мянган тн, хүнсний ногоо 303.1 га талбайд тариалж, 2.4 мянган тн ургац тус тус хураан авсан. Тариалалт суурь түвнээс 12.6 га талбайгаар, ургац 400 тн-оор нэмэгдэж, аймгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг 40.5 хувиар хангаж байна.	95.0
2.2.10	Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг олшруулж, сумуудад өвлийн болон нарлаг хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.	"Шинэ хөдөө-Булган" төслийн хүрээнд улсын төсвийн 119.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 40 м.кв хэмжээ бүхий 73 ширхэг нийлэг хальсан хүлэмж, 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 32 м.кв 25 хүлэмжийг 16 суманд, Хишиг-Өндөр суманд 92 м.кв багтаамж бүхий 2 хүлэмж, Хутаг-Өндөр суманд 60 м.кв багтаамж бүхий 4 хүлэмж, Сэлэнгэ суманд 430 м.кв багтаамж бүхий 6 хүлэмж, Бүрэгхангай суманд 24 м.кв багтаамж бүхий 1 хүлэмж, Булган суманд 240 м.кв багтаамж бүхий 2 хүлэмж, нийт 113 хүлэмж нийлүүлэгдэж, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг 7308 м.кв-аар нэмэгдүүллээ. ХХААХҮЯ-аас 1000 м.кв талбай бүхий өвлийн хүлэмжийн нэг маягийн зураг төслийг хүлээн авсан. Тус төслийн дагуу АНУ-ын элчин сайдын яамнаас 1000 м.кв өвлийн хүлэмж нийлүүлэхээр харилцан тохиролцсон. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Булган сумын Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд 160 м.кв өвлийн хүлэмж барьж ашиглалтад оруулсан. Мөн Хангал сумын "Эко Ханбуян" хоршоо өөрийн хөрөнгөөр 800 м.кв хэмжээ бүхий өвлийн хүлэмж барьж ашиглалтад орууллаа.	65.0
2.2.11	Сум дундын 500 тоннын багтаамжтай механикжсан зоорь барьж, ашиглалтад оруулна.	Бүгд Найрамдах Польш Улсын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төсөлд хамрагдахаар Булган суманд 1000 тоннын багтаамжтай механикжсан зоорь барих зураг төсөв, газрын асуудлыг шийдвэрлэж, холбогдох материалыг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн 70.0 сая төгрөгөөр Хутаг-Өндөр сумын төв, Хангал сумын Хялганат тосгоны төвд 500 тоннын багтаамжтай механикжсан зоорийн зураг төсвийг "Өрнөх гүн" ХХК боловсруулж байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сард хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.	30.0
2.2.12	Малын тэжээлийн ургамал тариалж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.	Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан эрхлэх зориулалтаар Могод суманд 264 га, Сайхан суманд 359 га, Булган суманд 3 га, Хутаг-Өндөр суманд 144 га, Баяннуур сумын Молцогт 100 га талбай, Бугат суманд 2 хоршоо, 44 өрхөд 275 га талбай, Орхон сум атаршсан 238.2 га, Дашинчилэн сум 167.5 га, нийт 1550.7 га газрыг олгож, 16 сумын хэмжээнд 5 тн үр нийлүүлж, аймгийн хэмжээнд тэжээлийн ургамал 6682 га талбайд хүрч, жилдээ 15-20 мянган тн ургац хураан авч байна. Бүрэгхангай суманд хэрэгжүүлсэн "Ногоон тэжээл" төслийн бүлгүүд 120 морины хүчин чадалтай 3 трактор, 35 морины хүчин чадалтай 3 трактор, 3 хаман боогч, 3 саран хадуур, Рашаант сумын малчид, иргэд өөрсдийн хөрөнгөөр ногоон тэжээл тариалах зориулалтаар 3 ширхэг трактор /хуучин/, 4 ширхэг хаман боогч, 3 ширхэг тармуур, Бүрэгхангай сумын "Өгөөж түрүү" ХХК хадлангийн саран тармуур, Хангал сумын 1 нөхөрлөл иж бүрэн техник, Сайхан сумын иргэд 2 ширхэг үрлэгч, 2 ширхэг хадуур, Сэлэнгэ сумын "Өрмөгтэй" ХХК өвс хаман боогч, Рашаант сумын "Эл Си Инженеринг" ХХК ногоон тэжээл тариалах иж бүрэн тоног төхөөрөмжийг газар тариалангийн зээлээр тус тус худалдан авч, техник шинэчлэл хийж байна. 2024 онд "Шинэ хөдөө" төслийн хөрөнгө оруулалтаар 2 суманд тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж нийлүүлэхээр тусгасан.	95.0
2.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай орчныг бүрдүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгоно.			

2.3.1	Жижиг, дунд, үйлдвэрлэлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	<p>Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоодыг чадавхжуулах, брэндинг хөгжүүлэх чиглэлд “Хөгжлийн шийдэл” ТББ, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) “Эдийн засгийн өсөлт болон бизнес эрхлэлтийг дэмжих төсөл”, Европын холбооны Свич-Эйшиа хөтөлбөрийн Эдийн Засгийн Ногоон Шилжилт төслийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, 8 аж ахуйн нэгжийг 60.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамруулав. 2022 онд “Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлогтой брэнд хоол шалгаруулах, хоол үйлдвэрлэлийн уламжлал ба инноваци”, 2023 онд “Улсын Залуу аварга тогооч-2023” ур чадварын уралдааныг орон нутагт анх удаа зохион байгуулж, аймгийн онцлог шингээсэн “Тэргүүн шимт” брэнд хоолыг бий болгов. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч” шагналын болзлыг 2022 оны А/262 дугаар захирамжаар баталж, 2021-2023 онд ахиц дэвшил, амжилт бүтээлтэй ажилласан 6 аж ахуйн нэгжийг шагнаж урамшуулав. Орон нутгийн брэндийг хөгжүүлэх, сурталчлан таниулах “Айрагны баяр”, “Намрын ногоон өдрүүд”, “Хангинахын шугуйн шагайн тойром”, ITM арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, Булган аймгийн хамтын ажиллагааны хүрээнд 299.8 сая төгрөгөөр оёдлын үйлдвэрийн байр авч, үйлдвэрийн байрны засварыг 59.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлээ. Тус байранд “Шинэ хөдөө-Булган” төслийн 76.0 сая төгрөгөөр оёдлын үйлдвэрийн 20 тоног төхөөрөмж, 26 дагалдах хэрэгсэл авч байрлуулан Булган сумын “Эл Жи Эс Эс” ХХК-тай “Орон нутгийн өмчийг түрээслүүлэх гэрээ” хийж, 40.0 сая төгрөгийн гарааны хөрөнгийн дэмжлэг үзүүлж, төрөл бүрийн хувцас үйлдвэрлэж байна. Ахуйн үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулав. Булган сумын үс засал, гоо засалчдын “Шидэт Урлаач” холбооны үсчидийг ОУ-ын болон улс, бүсийн ур чадварын уралдаанд оролцоход 13.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр Монголжингоо салоны үсчин Н.Амгаланбаатар бүс, улсын ур чадварын тэмцээнээс Тэргүүн байрын шагнал хүртлээ. Үсчин, хумс заслын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг сайжруулах 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 50 гаруй үсчин, хумс засалчдыг хамруулж, чадавхжуулав.</p>	100
2.3.2	Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлнэ.	<p>2020 онд 144 төсөлд 984.2 сая төгрөгийн зээл олгож, чанаргүй зээлийг 8.5 хувь бууруулав. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 16 сумын “Сум хөгжүүлэх сан”-ийн 2020 оны үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зээлийн эргэн төлөлт, сангийн үйл ажиллагааг сайжруулах аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгавар гаргаж, хэрэгжүүлэн ажилласнаар 800 зээлдэгч 1857.4 сая төгрөг эргэн төлснөөс 348 зээлдэгч 1017.1 сая төгрөгийн зээлийг барагдуулав. 2021 онд 10 сум 108 төсөлд 1114.1 сая төгрөгийн зээл олгож, чанаргүй зээлийг өмнөх онтой харьцуулахад 30.8 хувиар бууруулсан байна. 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангаас 55 бизнес төсөлд 1396.4 сая төгрөгийн зээл олгогдож, чанаргүй зээл өмнөх оноос 8.1 хувиар буурсан. 2023 онд 369 зээлдэгч 4.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, муу зээлийн ангилалд 189 зээлдэгч байгаа нь өмнөх онтой харьцуулахад муу зээлийн ангиллын зээлдэгчийн тоо 10.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тус сангаас 2023 онд Баяннуур, Сэлэнгэ, Хангал, Дашинчилэн, Рашаант, Булган, Бугат, Тэшиг, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Хутаг-Өндөр, Могод, Сайхан, Баян-Агт сумын 92 төсөлд 1.6 тэрбум төгрөгийн зээл олгож, 155 ажлын байр шинээр бий болж, 133 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. 2021 онд ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлд 294 иргэн 10.2 тэрбум, 47 аж ахуйн нэгж 4.0 тэрбум, нийт 14.2 тэрбум төгрөгийн зээл авч, төслүүд амжилттай хэрэгжиж байна. 2022 онд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сангаас 2 төсөл 160.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдлаа. 2023 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 11 төсөл 905.3 сая төгрөгийн зээлд хамрагдаж, 39 ажлын байр шинээр бий болж, 31 ажлын байр хадгалагдан үлдсэн. Хаан банкаар дамжуулан ипотекийн зээлийн 6.0 хувийн хүүтэй зээлийн урьдчилгаа төлбөрийн 60.0 хувийн батлан даалтад 15.8 сая төгрөг, ипотекийн зээлийн 3.0 хувийн хүүтэй зээлийн урьдчилгаа төлбөрийн 59.92 хувийн батлан даалтад 17.9 сая төгрөг, Төрийн банкаар ипотекийн зээлийн 3.0 хувийн хүүтэй зээлийн урьдчилгаа төлбөрийн 57.33 хувийн батлан даалтад 21.5 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулсан. Хүнсний хувьсгалын хөрөнгө оруулалтын зээлэнд 9 аж ахуйн нэгж 1.73 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгийн зээлэнд 53 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж, 3.65 тэрбум төгрөг авч, үйл ажиллагаа нь хэвийн явж байна. 2024 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд цахимаар 35 төсөл 3.9 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт уламжлаад байна.</p>	100

2.3.3	Булган суманд стандартын шаардлагад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудал шинээр барьж ашиглалтад оруулна.	Аймгийн төвд "Авзага трейд" ХХК 60 ортой "Дайчин ван" зочид буудал, 250 хүн хүлээж авах хүчин чадал бүхий ресторан, караоке баар, сургалтын танхим, саун бүхий цогцолбор төв, "Их Ачуут констракшн" ХХК Булган-Хөвсгөл чиглэлийн улсын чанартай авто зам дагуу 3 давхар зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний цогцолбор төвийг тус тус ашиглалтад оруулав. Аймгийн Засаг даргын 2021 оны А/162 дугаар захирамжаар "Супрема бүтик лоджес" ХХК-д 10814 м.кв газрыг зочид буудлын зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ 64.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, газар эзэмших гэрээ хийж, гэрчилгээ олгосон. Зочид буудлын каркас, ханын дүүргэлтийн ажил хийгдээд байна.	100
2.3.4	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.	2021-2022 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, 2023 оныг "Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, ажлын байрыг дэмжих жил" болгон зарлаж, төлөвлөгөөг 93 хувьтай хэрэгжүүлэн 25.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 273 ажлын байр шинээр бий болж, 431 ажлын байр хадгалагдаж үлдсэн. Аймгийн төвд 60 ортой "Дайчин ван" зочид буудал, 250 хүн хүлээж авах хүчин чадал бүхий ресторан, караоке баар, сургалтын танхим, саун бүхий цогцолбор, 3 давхар зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний цогцолбор төв, тус бүр 100 хүн хүлээж авах 2 заал бүхий ресторан, VIP караоке баар, Рашаант сумын Их элсэн тасархай аялал жуулчлалын гол чиглэлд "Сод хан трэвел" ХХК аялал жуулчлалын цогцолбор бүхий Япон "Суши" хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний төв, Сэлэнгэ суманд "Seven nuga", Хутаг- Өндөр суманд "Бүтэлэ", Бүрэгхангай суманд амралт, аялал жуулчлалын томоохон цогцолбор газрууд, Булган, Гурванбулаг, Орхон, Баяннуур, Дашинчилэн, Хангал сум, Хялганат тосгонд зочид буудал, зоогийн газар, хүнсний дэлгүүр, үсчин гоо сайхны салон зэрэг шинээр ашиглалтад орсон. "Шинэ хөдөө" төслөөс Бугат, Булган, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд 263.2 сая төгрөгийн өртөг бүхий 7 ширхэг сүү хөргөх танк нийлүүлснийг Булган сумын "Хатан мээж хайрхан" ХХК-ийн "Мээжийн сүү" үйлдвэрт түрээслүүлж, жилд дунджаар малчдаас 450 гаруй тн сүү цуглуулж, 300.0 гаруй сая төгрөгийн орлого олох нөхцөлийг бүрдүүлж байна. Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/478 дугаар тушаалын дагуу "Мээжийн сүү" үйлдвэрт урамшууллын хугацаанд 120 тн сүү нийлүүлсэн 210 малчинд 1 л тутамд 500 төгрөг, нийт 60.0 сая төгрөгийн урамшуулал олгов. Тэшиг суманд улсын төсвийн 2.98 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 250 толгой үхрийн ферм, хоногт 6 тн сүү боловсруулах хүчин чадалтай цөцгийн тосны үйлдвэр байгуулах газрыг шийдвэрлэж, ТЭЗҮ-ийг "Оргил цамхаг" ХХК, барилга бүтээн байгуулалтыг "Сейф транс" ХХК гүйцэтгэж, 75 хувийн явцтай байна. Булган сумын "Эко хүнс" ХХК-ийн "Чихэртэй ааруул", "Чихэргүй ааруул" нэрийн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулан баталгаажуулж, Хөдөө аж ахуйн МСҮТ-ийн ямааны сүүний ааруул Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан. 2023 онд "АПУ Дэйринг" ХХК, "Хөхүүр Агро" ХХК-тай хамтран Баяннуур, Дашинчилэн, Хишиг-Өндөр суманд сүүний хөргүүртэй танк байршуулж, хот суурин газраас алс малчдын сүүг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүллээ. Сайхан сумын Эрээний нүүрсний ордыг түшиглэж, жилд 10000 тоннын хүчин чадалтай сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг зөвлөх үйлчилгээний "SICA" ХХК-тай 61.4 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.	86.0
ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
3.1. Байгаль орчин. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.			

3.1.1	Ус, рашааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, хэмнэх, хуримтлуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Тайлант хугацаанд 14 сумын 38 булаг шандын эхийг байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 122.4 сая төгрөгөөр хашиж хамгаалсан байна. Баяннуур сумын "Баян" нуурыг сэргээх ажлын зураг төсөв хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Жишиг проект" ХХК-тай 34.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж, гүйцэтгүүлэв. 2021-2023 онд Сэлэнгэ, Хануй голын сав газрын захиргаатай хамтран усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, 418 гол горхи, 152 нуур тойром, 805 булаг шанд, 9 хөв цөөрөм, 1581 худгийн судалгаа тооллогын ажлыг хийж гүйцэтгэв. Хануй, Сэлэнгэ, Орхон-Чулуут, Туул, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаатай хамтран усны сан бүхий хамгаалалтын бүс тогтоож, Баян-Агт, Баяннуур, Булган, Бугат, Бүрэгхангай, Орхон, Могод, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд 400 ширхэг тэмдэгжүүлэлт суурилуулах ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 121.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX Хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор 2024 онд усны сан бүхий хамгаалалтын бүсэд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх 200 тэмдэгжүүлэлтийн ажлыг хийхээр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 40.3 сая төгрөг батлуулсан. Баян-Агт сумын Хануй, Цагаан гол, Сайхан сумын Хунт, Хутаг-Өндөр сумын Их булаг зэрэг нийт 13 рашааны дээжийг 2 удаа авч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнд хүргүүлэн физик-химийн шинж чанар, найрлагыг тодорхойлуулахад саармаг орчинтой, сул эрдэсжилттэй, гидрокарбонат-кальцийн төрлийн рашаан төст усны ангилалд хамаарагдаж байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны IX хуралдааны IX/16 дугаар тогтоолоор Гурванбулаг, Рашаант суманд хөв цөөрөм байгуулах газрын хайгуул судалгааны ажлыг зохион байгуулж, зураг төсвийг боловсруулах 30.0 сая төгрөгийг батлуулан "Жишиг проект" ХХК хөв цөөрөм байгуулах газрын судалгаа, зураг төсвийг 23.72 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв.	78.0
3.1.2	Аймгийн ойн сангийн ашиглалтад хамгаалалтын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	2021-2023 онд Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд 333 га, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 176 га, нийт 509 га талбайд ойжуулалт хийгдэж, 50 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэв. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 698.1 сая төгрөгөөр хийсэн. 2021-2023 онд ойн хортны судалгааны ажлыг ой бүхий 12 сумын 1129000 га талбайд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 80.9 сая төгрөгөөр, ойн хортны тэмцлийн ажлыг ой бүхий Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Тэшиг суманд 57782 га талбайд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 1139.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын Ойн нөөцийн хэлтэс ой бүхий 9 суманд 136600 га талбайд улсын төсвийн 9.5 сая төгрөгийн хөрөнгөөр ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, мэргэжлийн байгууллага улсын төсвийн 280.0 сая төгрөгөөр 7000 га талбайд ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг хийж гүйцэтгэв. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор 2024 онд усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны судалгааны болон тэмцлийн ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 759.7 сая төгрөгийг батлууллаа. 2021-2022 онд ойн ангиуд бургас, улиас, үхрийн нүдний мөчир 10000 ширхэг, нарс, шинэсний 4-5 кг үрийг тарилтад гаргасан. Хялганат тосгон, Хутаг-Өндөр, Булган сум дундын ойн ангиуд Бугат, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд насны I, II ангийн ойд арчилгааны огтлолтыг 180 га талбайд, мод бэлтгэлийн 36 аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр 20 га талбайд арчилгааны огтлолт хийж, 1250 га талбайд ойн цэвэрлэгээний ажлыг хийж энэ онд насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт 70 га талбайд хийхээр төлөвлөсөн. Баян-Агт, Бүрэгхангай, Бугат, Орхон, Хангал, Хишиг-Өндөр, Сэлэнгэ суманд 2021-2023 онд "Хожуул" төслийг хэрэгжүүлж, 394.4 га талбайд тусгаарлалт хийж, 264960 ширхэг хожуулаас 5410.4 м.куб модыг аймаг, сумын иргэдийн түлшний хэрэгцээнд олгох ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 150.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв.	100
3.1.3	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлнэ.	2021-2023 онд Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хөгнө-Тарны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Дашинчилэн сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан 30 тонн өвс, 19.2 тонн давс, 4 тонн хужир, 12 тонн тэжээлийн будааг 188 цэг мараанд тавьж, моцог хандгай, халиун буга, бор гөрөөс зэрэг нэн ховор, ховор амьтдын идэш тэжээлийн нөөцийг бий болгож, өсөн үржих боломжийн биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 40.0 сая төгрөг зарцууллаа. 2024 онд нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 20.0 сая төгрөг батлуулсан.	100

3.1.4	Газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг судалгаанд үндэслэн зохион байгуулж, сүлжээг өргөтгөнө.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX хуралдааны IX/05 дугаар тогтоолоор Тэшиг сумын Дулаан хан уул орчмын 15516.5 га газрыг "Байгалийн цогцолборт газар"-ын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XV хуралдаанаар Хангал сумын "Бүрэнгийн нуруу" орчмын 12092.49 га газрыг "Байгалийн нөөц газар"-ын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах саналыг тус тус Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжиллаа. Гурванбулаг сумын Агьт багийн "Самбуу цагаан чулуут", "Саарал ямаатын гозгор" орчмын 1441.96 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах саналыг Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн. Баян-Агт сумын ИТХ-ын 10 дугаар хуралдааны 10/05 дугаар тогтоолоор, "Шарга нуур" 3669 га газрыг, 10/06 дугаар тогтоолоор, "Дулаан хан уул" 17049 га газрыг, 10/07 дугаар тогтоолоор, "Бага нуур" 47.73 га газрыг, 10/08 дугаар тогтоолоор "Цагаан гол" рашаан хайлааст тохой 415.85 га газрыг, 10/09 дүгээр тогтоолоор, "Цэгээн бөөргийн нуур" 1350.3 га газрыг, 10/10 дугаар тогтоолоор "Хануй" рашааны дэнж хүрэн толгой орчим 454.60 га газрыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэв. Аймгийн нийт газар нутгийн 16.13 хувь улсын тусгай хамгаалалттай, 20 гаруй хувь нь орон нутгийн тусгай хамгаалалттай байна.	90.0
3.1.5	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдол доройтлыг бууруулж, шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлнэ.	2021-2023 онд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор 1536151 га газрын 37775.5 тн, 378 гол горхи, уст цэгийн 5199.8 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн төвлөрсөн цэгт аваачиж, үхсэн малын 30742 сэг зэм, 3909 нохой, 272 муурыг устгаж, энэ ажилд давхардсан тоогоор 1184 аж ахуйн нэгж, байгууллага, 21363 хүн, 936 автомашин техниктэй оролцож, аймаг, орон нутгийн төсвийн 420.9 сая төгрөг, 25.8 тн шатахуун зарцуулсан. 2024 онд аймгийн хэмжээнд "Цэвэр орчин - цэмцгэр Булган" аян, иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 50.0 сая төгрөг батлууллаа. 2022, 2023 онд хог ачиж тээвэрлэх, бохир соруулах зориулалт бүхий 18 автомашиныг 903.4 сая төгрөгөөр худалдан авч сумдад хуваарилсан. Тэшиг, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр сум Европын холбооны SWITCH Asia-II хөтөлбөрийн санхүүжилтээр Каритас Чех Републик, Монголын тогтвортой хөгжлийн гүүр ТББ хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төслийн хүрээнд хог хаягдлыг төрлөөр ангилан нийлүүлж байна. 2024 онд хатуу хог хаягдлыг ангилан ялгах боловсруулах зорилгоор хог түрж булах 3 ширхэг техник, хатуу хог хаягдлыг ачиж, тээвэрлэх 2 ширхэг автомашин, бохир соруулах 3 ширхэг автомашин худалдан авах зорилгоор 790.0 сая төгрөг батлууллаа. 2021 онд Булган сумын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах, дарж булах ажлын гүйцэтгэгчээр "Алистр констракшн" ХХК шалгарч төвлөрсөн хогийн цэгийн 0.8 га газрын хог хаягдлыг хумьж цэвэрлэн дарж булах, шинээр үүсэх хог хаягдлыг хаях 1 га нөөц талбайг бэлтгэж, талбайн даланг тэгшлэн хашаа барих ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 75.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Булган сумын төвлөрсөн хогийн цэгийн дэргэдэх хог ангилан ялгах цехэд ангилсан хог хаягдлаар бүтээгдэхүүн, бэлдэц хийх, аюултай хог хаягдлыг түр хадгалах 21х15 метр хэмжээтэй агуулахын барилгын ажлуудад улсын төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарцуулав.	98.0

3.1.6	<p>"Нүхэн ОО -оо өөрчилъе" аяныг жил бүр зохион байгуулж, гэр хорооллын айл өрх, албан байгууллагыг байгальд ээлтэй боловсон 00-той болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гурванбулаг, Сэлэнгэ сумын хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэг, Баяннуур, Могод, Хангал сумын сургууль, дотуур байр, цэцэрлэг, 2023 онд хичээлийн 7 (Баян-Агт 1, Дашинчилэн 2, Орхон 1, Сайхан 1, Хишиг-Өндөр 2), дотуур байрны 6 (Баян-Агт 2, Орхон 1, Сайхан 2, Хишиг-Өндөр 1), сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 5 (Баян-Агт 1, Бугат 1, Дашинчилэн 1, Сайхан 1, Хишиг-Өндөр 1), нийт 18 объектын стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн өрөөтэй болгох ажлыг улсын төсвийн 1045.0 сая төгрөгөөр хийж, ашиглалтад оруулсан. 2021-2022 онд Булган сумын гэр хорооллын 200 айл өрхөд боловсон, соруулдаг нойл, "Цоожид", "Эмийн цэцэглэн" өрхийн эрүүл мэндийн төв, "Жаргалант" зуслан, "Цэцэгжин" зах, цэнгэлдэх орчим, барилгын 36 айлын хэсэг болох нийтийн эзэмшлийн 9 байршилд 18 соруулдаг нойл барих ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 257.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. 2023 онд аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулан 30 ширхэг зөөврийн эко нойлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 154.6 сая төгрөгөөр худалдан авч Булган сумын Тохижилт үйлчилгээний ангид хүлээлгэн өгсөн. Тэшиг сумын Харгал нуурын орчим 1, Баян-Агт сумын Хануйн рашааны хүрэмд 2 био нойлыг сум орон нутгийн төсвийн 45.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн аймгийн хэмжээнд аялал жуулчлал, амралтын газар, үйлчилгээний газар, айл өрх 333 боловсон соруулдаг нойлтой болсон. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Булган сумын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн газрын 2715 нүхэн нойлд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв. 2024 онд сумын төвийн айл өрхийг хог ангилан ялгах хогийн савтай болгох ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 190.0 сая төгрөг батлууллаа.</p>	100
3.1.7	<p>Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.</p>	<p>2021-2023 онд цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх урьдчилсан мэдээний чанар 80.7 хувь, онч 92.2 хувь, илрүүлэлт 100 хувьтай байна. Тайлант хугацаанд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулга мэдээ 74, сэрэмжлүүлэг мэдээ 37, урьдчилан сэргийлэх мэдээ 2 удаа гаргаж, цаг тухайд нь багц мессежээр давхардсан тоогоор 198 байгууллага, 723942 иргэнд өгч үйлчилсэн. Ус, цаг уур, орчны шинжилгээний төв болон Гурванбулаг, Тэшиг сумын цаг уурын өртөөний барилгыг барих, засварлах ажилд 145.0 сая төгрөг зарцуулж агаар дахь тоосонцор хэмжигч суурин багажийг 2021 онд ашиглалтад оруулсан бөгөөд 2023 онд нарийн ширхэглэлт тоосонцор (PM2.5)-ын 330 удаагийн хэмжилтээр сарын дундаж утга 0.020 мг/м.куб байна. Агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар исэлд тус бүр 533 удаагийн хэмжилт хийж, хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 0.009 мг/м.куб, азотын давхар ислийн сарын дундаж агууламж 0.032 мг/м.куб байгаа нь агаарын чанарын MNS 4585:2016 стандартаас давж бохирдсон үзүүлэлт ажиглагдаагүй. Гадаргын усны 6 голын 6 усны харуулаас 32 усны дээж ирж, 18 үзүүлэлтээр химийн шинжилгээ хийгдсэн. Шинжилгээний дүнг усан орчны чанарын MNS 4586:1998 стандарттай харьцуулахад бохирдол хэвийн хэмжээнд, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт ажиглагдаагүй байна. Цаг уур, орчны шинжилгээний газраас агаарын бохирдлын тоосонцрыг хэмжих зөөврийн багажаар хангагдсан. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 4, 5 дугаар сард үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг 7 удаа зохион байгуулснаар бэлчээрийн ургамлын ургалтын байдал нийт нутгийн түймрийн эрсдэлийн 3, 4 дүгээр зэрэг буюу аюултай, түймэр гарах нэн аюултай зэрэгт хүрсэн нөхцөлийг бууруулж ажилласан бөгөөд 2023 онд Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумын залгаа нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарч унтарсан хэдий ч хуурайшилтын зэргийг бууруулах, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулж, 0.0-2.0 мм хур тунадас нэмэгдүүлэн оруулж, ой хээрийн түймрийн эрсдэлийг ихэнх нутгаар бууруулж, 1-р зэрэгт оруулсан.</p>	100
<p>3.2. Аялал жуулчлал. Байгаль, түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжтэй салбар болгон хөгжүүлнэ.</p>			

3.2.1	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулан баталгаажуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	Улаанбаатар хотод жил бүр зохион байгуулагддаг Олон улсын аялал жуулчлалын "ITM" үзэсгэлэнд 2021-2023 онд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг 50 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, 6000 орчим хүнд үйл ажиллагаагаа сурталчлан 8 төрлийн 27000 орчим гарын авлага материалыг тараан ажиллаж, 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгууллаа. 2022-2023 онд аймгийн хэмжээнд 5 эвент арга хэмжээг төлөвлөн "Хангинахын шугуйн шагайн тойром"-ын арга хэмжээг 5, 6 дугаар сард Орхон аймагтай хамтарч, 7 дугаар сард "RFC MONGOLIA BULGANKHANGAI 2022" олон улсын бартаат замын уралдаан, 8 дугаар сард "АЙРАГ НААДАМ" арга хэмжээ, 10 дугаар сард "Airagday" арга хэмжээ, "ITM Mongolia" арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Эдгээр эвент арга хэмжээг зохион байгуулахад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 453.0 сая төгрөгийг зарцуулан ажиллаж, давхардсан тоогоор гадаадын 19360, дотоодын 267820 орчим аялагчид эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор зорин ирсэн байна. Дээрх арга хэмжээнүүдэд оролцогчдын тоо 2023 онд 2022 онтой харьцуулахад 13.0 хувиар өссөн дүнтэй байна. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн, рашаан сувиллын, түүх соёлын болон музейн үзмэрүүдийн виртуал танилцуулгыг, мөн монгол хэл дээр 14, англи хэл дээр 7 контент видеоог хийж, олон нийтэд танилцууллаа. Аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ, хөгжүүлэх зорилго бүхий "visitbulgan.mn" веб сайтыг 44.2 сая төгрөгөөр "Ай Өү технологи" ХХК гүйцэтгэн 2024 оны 3 дугаар сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Аялагч, жуулчдад зориулсан аймгийн аялал жуулчлалын газрын зураг, танилцуулгыг "МРМ" ХХК англи, монгол хэлээр 6500 ширхэгийг хэвлэн хүлээлгэж өгсөн. Дээрх аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ хөгжүүлэх ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 148.4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Цахим орчинд "Visit Bulgan-Булганаар аялагчид" фэйсбүүк группыг 22900 гаруй гишүүнтэй идэвхтэй хөтөлж, Булган аймгийг сурталчилж байна.	96.7
3.2.2	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжин, хамтран ажиллана.	"Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлцгээе", "Хогоо шийдэж-Жорлонгоо өөрчилъе" уриан дор 1 дүгээр сарын 21-ний өдөр "VISIT BULGAN-2023" аялал жуулчлалын форумыг Хангал сумын Хялганат тосгонд зохион байгууллаа. Форумын үйл ажиллагаанд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд оролцож, өвлийн экстрим аяллыг хөгжүүлэх боломж, аяллын улирлыг уртасгах талаар санал солилцсон. Зөвлөгөөний үеэр "Өвлийн спортын наадам-2023" арга хэмжээг зохион байгуулж, 16 сум, 1 тосгоны 1000 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. Мөн "Өвлийн аялал" фото зургийн уралдааныг зарлан шалгарсан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргасан. Тус ажлыг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 5.0 төгрөг зарцуулсан. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлснээр жилийн дөрвөн улирлын турш жуулчдыг нутагтаа бүрэн татах нөхцөлийг бүрдүүлэх юм.	100
3.2.3	Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулна.	2021 онд Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Сувдан элс" ХХК түр буудаллах цэг байгуулах ажлыг гүйцэтгэлээ. 2022 онд улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Рашаант сумын Элсэн тасархайд "Өвөлжөөн булаг" ХХК, Баян-Агт сумын Хануй рашааны дэнж дээр "Цонхот" ХХК отоглох цэг байгуулах ажлыг гүйцэтгэв. 2023 онд Дашинчилэн сумын Хар бухын голд аж ахуйн нэгжийн хөрөнгөөр, Булган сумын Хужир толгойд "Хульж ресорт" ХХК түр буудаллах цэгийг өөрийн хөрөнгөөр барьсан. Тэшиг сумын Харгал нуур, Давааны ар хэмээх газарт орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөгөөр отоглох цэг, боловсон нойл барьсан.	100
3.3. Уул уурхай. Уул уурхайн салбарт экологийн болон нийгмийн хариуцлагын тогтолцоог бий болгон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аймгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.			

3.3.1	<p>Ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, байгаль орчны сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, аюулгүй ажиллагааг хангасан ил тод, хариуцлагатай уул уурхайг бий болгоно.</p>	<p>2024 оны 2 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын 79 аж ахуйн нэгжийн 49868.95 га, хайгуулын 33 аж ахуйн нэгжийн 174706.5 га талбайд тусгай зөвшөөрөл олгогдсон байна. 2021 онд “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ус хангамжийн цехийн ус өргөх 2 дугаар станцад байрлах 2907 дугаартай усны тоолуурт ээлжит улсын баталгаажуулалт хийлгэж, суурилуулан, Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч “Бүрдэл майнинг” ХХК, “Хос хас” ХХК, “Хоту” ХХК, “Платинум ланд” ХХК, “Тэргүүн майнинг” ХХК усны тоолуур шинээр суурилуулан үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд Бүрэгхангай сумын төмрийн хүдрийн “Фокус метал майнинг” ХХК, уул уурхайн олборлолтын “Өгөөж баянхангай” ХХК, 2023 онд Бүрэгхангай суманд “Мөнх нархан орд” ХХК, Дашинчилэн суманд “Батбродерс майнинг” ХХК унд, ахуйн усны шугамд тус тус шинээр тоолуур суурилууллаа. Ингэснээр аймгийн хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй 10 аж ахуйн нэгж усны тоолууртай болоод байна. Аймгийн Засаг дарга болон Бүрэгхангай, Дашинчилэн сумын Засаг дарга нар 2022-2023 онд уул уурхайн 19 аж ахуйн нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 71 хүүхдийн сургалтын төлбөр, 3 хүүхдийн эмчилгээний зардал болох 420.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхээр тогтож, одоогийн байдлаар 350.0 сая төгрөг, 66 хүүхдийн сургалтын төлбөрийг төвлөрүүлээд байна. Бүрэгхангай сум 23 уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн дэд бүтэц, ажлын байр нэмэгдүүлэх, хандивын асуудлаар гэрээ байгуулж, 1454.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 1057.5 сая төгрөгийг төвлөрүүлээ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 аж ахуйн нэгж, зам барилгын ажил гүйцэтгэгч 4 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл, 6 иргэнд урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулж, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд 22 зөрчил илэрч, газар дээр нь арилгуулан, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгж, 3 нөхөрлөлд Зөрчлийн тухай хуулиар 40.0 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал тусгай зөвшөөрөлгүй олборлосон 3 аж ахуйн нэгж, 6 иргэнд Зөрчлийн тухай хуулиар 12.2 сая.төгрөгийн шийтгэл, 4750.0 мян.төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 90 м.куб элс хурааж улсын орлого болгосон.</p>	96.7
3.3.2	<p>Уул уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.</p>	<p>Сайхан сумын нутагт орших “Эрэний ихэр уул” нэртэй 65.59 га талбай бүхий ашигт малтмалын MV-014228 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Илчит металл” ХХК-ийн Эрээний чулуун нүүрсний орд нь 659501.9 тонн нөөцтэй бөгөөд 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник шинэчлэлт хийж, үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд “Нүүдэлчин Айрон ресорс” ХХК-ийн MV-017539 тоот тусгай зөвшөөрөлтэй Өлзийт-Овоогийн ордыг ил аргаар төмрийн хүдрийг олборлон, боловсруулах төслийн үйл ажиллагаа эхлүүлснээр 30.0 хувиас доош агуулгатай 70.0 мянган метр куб хүдрийг хуурай түр баяжуулах үйлдвэрээр оруулж, овоолго үүсгэн ангилан үйл ажиллагаа явуулсан. 2022 онд “Нүүдэлчин Айрон ресорс” ХХК-ийн MV-017539, “Фокус металл майнинг” ХХК-ийн MV-021708, MV-015152, MV-012263 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Өлзийт-Овоо”, “Захцаг уул”, “Худаг байшинтын орд”-ыг олборлон, боловсруулах ажлыг явуулсан. 2023 онд “Фокус металл майнинг” ХХК MV-021708, MV-015152, MV-012263 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Захцаг уул”, “Худаг байшинтын орд”-оос 24000 тн төмрийн хүдрийн нойтон баяжмал олборлолт хийлээ.</p>	95.0

3.3.3	Уул уурхайн олборлолтын болон барилга, авто зам, дэд бүтэц, бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2022-2023 онд Дашинчилэн сумын Дорголот багийн "Цагаан чулуут" гэх газар гар аргаар алт олборлосны улмаас эвдэрсэн 1.8 га газрыг нөхөн сэргээх ажлыг "Батбродерс майнинг" ХХК гүйцэтгэлээ. Давхардсан тоогоор Бүрэгхангай сумын тусгай зөвшөөрөлтэй 21 аж ахуйн нэгж дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон 72.7 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийж, биологийн нөхөн сэргээлтийг 12.1 га, техникийн нөхөн сэргээлтийг 63.2 га талбайд хийж гүйцэтгэлээ. 2021 онд Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал олборлосон 6 иргэний газрын хэвлийд учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, хохирол тооцоход 18.0 сая төгрөг зарцуулсан байна. 2022 онд Дашинчилэн суманд "Өвөр хадат" гэх газарт 2, "Овоо" гэх газарт 2, Бүрэгхангай сумын "Цоохор морьт" гэх газарт 2, "Наран гоулд" ХХК-ийн талбайд хууль бус алт олборлолтын 1 хэрэг гарч, 29.5 сая төгрөгийн хохирол тогтоолгох ажил хийгдсэн. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газартай байгуулсан гэрээний хүрээнд 2022 онд "Эрдэнэт-Хялганат" чиглэлийн 53.6 км авто замын өргөтгөл, засвар шинэтгэлийн ажлын гүйцэтгэгч "Замын битум" ХХК-д 7 карьер, "Хурдны зам" ХХК-д 8 карьер, "Жавхлан харгуй" ХХК-д 3 карьер, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Хангал-Хялганат" чиглэлийн эхлэлийн хатуу хучилттай 10 км авто замын гүйцэтгэгч "Увт инвест" ХХК-д 3 карьер, "Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг" чиглэлийн хатуу хучилттай 31.08 км авто зам барих ажлын гүйцэтгэгч "Рэс" ХХК-д 5 карьерын зөвшөөрлийг Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, төмөр замын тусгай журам"-ын хүрээнд олгож, тухайн карьер олгосон газарт нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийлгэж хүлээн авна.	76.7
3.4 Дэд бүтэц. Аймгийн дэд бүтцийн салбарыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.			
3.4.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хөгжлийн хэтийн зорилт, хот төлөвлөлттэй уялдуулан газар олголтын үйл ажиллагааг ил тод болгоно.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийг 2020 оны аймгийн төсөвт тусгаж, гүйцэтгэгчээр "Вектор мэн" ХХК шалгарч аймгийн Засаг даргын 2020 оны А/375 дугаар захирамжаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2020-2021 онд боловсруулж, аймгийн ИТХ-ын 2022 оны Х/18 дугаар тогтоолоор батлуулж, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 94 арга хэмжээг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем (egazar.gov.mn)-д байршуулан иргэд, олон нийтэд нээлттэй үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах төсөвт багтаан Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг гүйцэтгүүлж, 2020-2021 оны сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, цахим системд байршуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үе шаттайгаар тусган газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2023 онд аймгийн хэмжээнд 5298 нэгж талбарын 124051.72 га газрын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4145 нэгж талбарын 4020.4 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, өмчлүүлсэн. Газар нөхөн сэргээх, хамгаалах, нийтийн эдэлбэрийн газарт шугам сүлжээ татах, ногоон байгууламж үүсгэх арга хэмжээг 120031.32 га талбайд хэрэгжүүлжээ. Аймгийн Засаг даргаар батлуулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын Засаг даргаар батлуулсан 16 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 17 хувьтай хэрэгжиж зорилтод түвшинд хүрсэн. 2024 онд ерөнхий төлөвлөгөөний дагуу 2590 нэгж талбарын 2302.97 га газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашигуулах, 59 арга нэгж талбарын 26011.81 га газрыг хамгаалах, сайжруулах, ашиглуулах, нөхөн сэргээхээр, нийтийн эдэлбэрийн зам, шугам сүлжээний 5 нэгж талбарын 73.41 га газрыг хамгаалалтын зурвасаар эзэмшүүлэхээр тус тус төлөвлөсөн. Аймгийн байгаль хамгаалах сангийн 408.9 сая төгрөгөөр Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр гэсэн 9 сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын гүйцэтгэгчээр "Вектор мэн" ХХК шалгарч 116/2023 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлын явц 64.0 хувьтай байна.	100

3.4.2	Булган хотын ерөнхий төлөвлөгөөг /ногоон хот төлөвлөлт/ шинэчлэн боловсруулж, зарим сум, багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийнэ.	Бугат сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Эрхэт констракшн" ХХК гүйцэтгэж байгаа ба төлөвлөлтийн хил, суурь судалгааны ажил дуусаж, ерөнхий төлөвлөлтийн ажлын явц 70.0 хувьтай үргэлжилж байна. Рашаант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Циркулпроект" ХХК шалгарч төлөвлөлтийн дунд хугацааны тайланг хүргүүлсэн ба ажлын явц 60.0 хувьтай байна. Дашинчилэн сумын хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Өрнөх гүнт" ХХК гүйцэтгэж, тус сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэж өгсөн ба ажлын явц 90.0 хувьтай байна. Булган сумын 4 дүгээр багийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Эрхэт констракшн" ХХК гүйцэтгэж, эцсийн тайланг хүргүүлж, дулааны төлөвлөлтийн зургийн ажлын явц 85.0 хувьтай байна. Эдгээр ажлуудыг орон нутгийн төсвийн 230.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлсэн. Хутаг-Өндөр сумын Дондогийн булаг орчмын суурьшлын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Циркулпроект" ХХК шалгарч 66.2 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Булган сумын 4-р баг (Зүүнтүрүү)-ийн хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгөөр "Эрхэт констракшн" ХХК гүйцэтгэж байна. 2023 онд орон нутгийн төсвийн 492.6 сая төгрөгөөр тус багийг төвлөрсөн ундны цэвэр усан хангамжид холбох зураг төсвийг боловсруулж, 1-р ээлжид гүний худаг, усан сан, 3 байршилд ус түгээх ухаалаг худгийн барилгын ажлыг "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэж байна. Төвлөрсөн дулаан хангамжийн системийг хийлгэхээр хувийн хэвшлүүдэд санал тавин ажиллаж байна. Эдгээр төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээр Булган сумын 4-р баг ерөнхий төлөвлөлтийн дагуу хөгжих, иргэд төвлөрсөн ус, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэрээс хангагдах юм.	80.0
3.4.3	Аймгийн инженерийн хийцтэй барилга байгууламжуудад үнэлгээ хийж, нийтийн эзэмшлийн орон сууцнуудын барилгын гадна өнгө үзэмж сайжруулж, дулаан алдагдлыг бууруулна.	Орон нутгийн 2022 оны төсөвт 50.0 сая төгрөг тусган Булган сумын МСҮТ-ийн дадлагын байр, "Эрдмийн Өргөө" цогцолбор сургуулийн хичээлийн байрны 1 дүгээр блок, Сайхан сумын сургуулийн хичээлийн байр, Бугат сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Хялганат тосгоны Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Захирагчийн ажлын албаны барилга, Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байр, Могод сумын Соёлын төв гэсэн 9 барилгыг паспортжуулсан. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60.0 сая төгрөг тусган Булган сумын төвд МСҮТ-ийн дадлагын байр, Сэлэнгэ сумын ЕБС-ийн даралтат цамхаг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн төв байр, Тэшиг сумын соёлын төвийн барилга, Хутаг-Өндөр сумын 320 хүүхдийн суудалтай хичээлийн байр, Гурванбулаг сумын ЕБС-ийн 80 ортой дотуур байрны барилга, Дашинчилэн сумын хүүхдийн цэцэрлэг, Орхон сумын соёлын төвийн барилга, Хялганат тосгоны Сэлэнгэ мөрний гүүр, Булган сумын 1 дүгээр сургуулийн 2 давхар дотуур байр зэрэг 11 барилгыг паспортжуулахаар даалгавар боловсруулан гүйцэтгэгчийг шалгаруулсан. 2024 оны орон нутгийн төсөвт 30.0 сая төгрөгөөр нийгмийн дэд бүтцийн шаардлагатай барилгыг паспортжуулахаар даалгавар боловсруулж байна. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 12, 14, 15, орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18а, 18б байрны барилгын гадна ханын засварын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулав. Мөн орон нутгийн төсвийн 342.0 сая төгрөгөөр аймгийн төвийн 16 байрны 40 орцны өнгө засал, хаалга шинээр хийх ажлыг "Өвөлжөөн булаг" ХХК гүйцэтгэж, гэрээний дагуу 2022 онд ашиглалтад оруулсан. 2023 оны орон нутгийн төсөвт 350.0 сая төгрөг тусган Булган сумын 11, 19, 32 дугаар байрны фасадны засварын ажлыг төлөвлөн гүйцэтгэгчээр "Гурван уулын хишиг" ХХК шалгарч 345.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан.	80.0

3.4.4	Аймгийн Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж, сум суурин газарт спортын болон хүүхдийн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, төв, суурин газрын ногоон байгууламжийг 50 хувиар нэмэгдүүлнэ.	Аймгийн хүүхэд, залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөг Булган хотын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2023 онд соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн захиргаа аж ахуйн конторын барилга, спорт тоглоомын барилгын засвар, "Ид шидийн орон" тохижилтын зураг төсвийг хийлгэж байна. Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн тоглоомын талбайн задгай тайз, явган хүний зам тавихаас гадна шинээр тоглоомын тоног төхөөрөмж суурилуулах бүтээн байгуулалтын ажил хийхээр тендер зарлалаа. Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр суманд 2021-2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн тоглоомын талбай байгуулж, Бүрэгхангай, Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр сумын хүүхдийн тоглоомын талбайг улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан. Булган сумын 2 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбайг орон нутгийн төсвийн 56.0 сая төгрөгөөр "Арвин ган бум" ХХК, Хангал сумын хүүхдийн тоглоомын талбайг "Багандант" ХХК 407.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулав. 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Булган, Баян- Агт суманд тоглоомын талбайн ажил хийгдэх бөгөөд 2024-2026 онд бүрэн хийгдэж дуусах юм. Төв суурин газруудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд 100.0 сая төгрөг төсөвлөн 21000 ширхэг мод бут тарьж, 680 ширхэг нарс модыг арчлан 5000 м.кв талбайг зүлэгжүүлж, 12000 м.кв талбайн зүлгэнд арчилгаа хийж, 3500 м.кв талбайд цэцгийн мандал байгуулж, 2022 онд 1.5 км газарт 12 нэр төрлийн 8 өнгийн 12600 ширхэг цэцгийн үрсэлгээг хийж арчлан 100 хувь ургуулсан. Булган сумын 18 дугаар байрны орчим 300 м.кв талбайд шинээр хамгаалалтын торон хайс, зүлэгжүүлэлтийн ажлыг хийж хуучин зүлэгжүүлсэн талбайн халцарсан 100 м.кв талбайд нөхөн тарилт, арчилгаа хийж аймгийн хэмжээнд 26500 м.кв талбайг зүлэгжүүлэн 2500 м.кв талбайд цэцэгжүүлэлт хийж, 159084 ширхэг мод бут тарьж арчлан ургуулсан. "Булган хангай" МСҮТ-ийн баруун талын биеийн тамирын талбайд иж бүрэн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хүүхэд залуучуудын амрах талбайг орон нутгийн төсвийн 77.7 сая төгрөгөөр гүйцэтгэж ногоон байгууламжийг 15.6 хувиар нэмэгдүүлээд байна.	76.7
3.4.5	Булган сумын гэр хорооллын гудамж, талбайг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.	Булган сумын 1, 4, 6 дугаар багийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажлыг орон нутгийн төсвийн 380.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Сервис по сименс" ХХК шалгарч, угсралтын ажлыг гүйцэтгэн 2022 онд ашиглалтад оруулсан. Булган сумын гэр хорооллын гудамж зам талбайн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх ажилд аймаг, сумын орон нутгийн төсөвт 2023 онд 1.4 тэрбум төгрөг тусгагдаж 1250.0 төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэв. Булган сумын 2, 3, 5 дугаар багийн гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн зураг төслийг боловсруулсан. Мөн 4 дүгээр багт 3 чиглэлд 52 ширхэг гэрэлтүүлэг, Хужир толгойгоос отоглох цэг хүртэл 65 ширхэг, Цагаан хаалганаас Байгаль орчин, аялал жуулчлалын газар хүртэл 48 ширхэг, нийтийн орон сууцны 22 байрны гадна фасадны гэрлэн чимэглэл, гудамжны гоёлын гэрэлтүүлгийн ажлыг тус тус гүйцэтгэв. Дээрх ажлуудын дүнд Булган сумын төвийн суурьшлын бүсийн гэрэлтүүлэг 8.0 хувиар нэмэгдэж, 20.0 хувьд хүрч хотын өнгө үзэмж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдлээ.	100
3.4.6	Аймгийн төвийн хэрэглэгчдийг хэрэглээний халуун устай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Булган сумын айл өрх, аж ахуйн нэгжийг үе шаттайгаар хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын хүрээнд 2 болон 5 дугаар УДДТ-ийн үйлчилгээний хүрээний нийтийн орон сууц, төр төсвийн байгууллагыг хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын зураг төслийг "Онолт од" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2021 онд аймгийн орон нутгийн төсвийн 348.0 сая төгрөгөөр "Нью гранд пропертийз" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Тус ажлын хүрээнд 1, 6 дугаар цэцэрлэг, 18а, 18б байрны хэрэгцээний халуун усны шугамын угсралтын ажил дуусаж, 2022 оны 05 дугаар сард ашиглалтад хүлээлгэж өгсөн. 2022 онд 2 дугаар шатны ажилд аймгийн орон нутгийн төсвийн 350.0 сая төгрөгөөр 14, 15, 22, 23 дугаар нийтийн орон сууцныг холбох ажлыг "Сувдан элс" ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. 2023 онд 160 ортой Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ортой төрөх тасаг, Спортын ордон, 36 айлын 1 орон сууцныг хэрэглээний халуун усны шугамд холбох ажлыг "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэхээр 498.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажил үргэлжилж байна. Тус ажил ашиглалтад орсноор аймгийн төвийн төрийн 8 байгууллага, 9 орон сууцны 209 айл өрх хэрэгцээний халуун устай болно. 2024 онд Булган сумын 16, 17, 208 дугаар байрны хэрэгцээний халуун усны угсралтад 300.0 сая төгрөг тусгасан.	100

3.4.7	Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг сайжруулна	Хялганат тосгоны төвийн 10 км авто замыг "Увт инвест" ХХК гүйцэтгэсэн. Одоогоор улсын комисс хүлээж аваагүй байна. Дашинчилэн сумын 1.8 км авто замын ажлыг "Таван богд офроуд" ХХК улсын төсвийн 1492.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Орхон сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлыг орон нутгийн авто замын сангийн 217.3 сая төгрөгөөр, Бугат сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлыг 218.2 сая төгрөгөөр "Энх алтаргана" ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Мөн Рашаант сумын төвийн авто замын засварт 100.0 сая төгрөг, Хишиг-Өндөр сумын төвийн авто замын засварт 60.0 төгрөг тусган, гүйцэтгэгчээр "Энх алтаргана" ХХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. Аймаг, сумын орон нутгийн 629.5 сая төгрөгөөр Тэшиг сумын төвийн замын гүйцэтгэгчээр "Ингүүмэл зам" ХХК шалгарч 2023-2024 онд гүйцэтгэнэ. Сайхан, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Гурванбулаг суманд нийт 11122.1 сая төгрөгөөр сумын төвийн авто замын ажлыг 2024-2026 онд хэрэгжүүлнэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Бугат, Орхон суманд 800.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Рашаант суманд 500.0 сая төгрөгөөр авто замын ажлыг үргэлжлүүлнэ.	63.3
3.4.8	Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулж, сурагчдын автобустай болгоно.	Булган сумын нийтийн эзэмшлийн авто зогсоолын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Булган сумын 5 дугаар баг "Өнө мандал" дэлгүүрийн урд талд "Арвин ган бумба" ХХК 865 м.кв бетон авто зогсоолын талбай, явган хүний зам тавьж, улсын комисс байнгын ашиглалтад 2022 онд хүлээн авсан. Тус ажлыг Булган сумын Засаг даргын Тамгын газартай 75.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэсэн. 2023 онд 11 дүгээр байрны зүүн талд 1062 м.кв авто зогсоол, 150 м.кв ногоон байгууламж, 11 ширхэг гудамжны гэрэлтүүлэг, 83 м.кв явган хүний замын ажлыг орон нутгийн төсвийн 78.6 сая төгрөгөөр "Арвин ган бумба" ХХК хийж гүйцэтгэв. Орон нутгийн төсөвт Булган сумын сургуулийг автобусаар хангахаар 80.0 сая төгрөг тусгасан бөгөөд аймгийн Орон нутгийн өмчийн газраас худалдан авах тендерийг зарлаж, Булган сумын хот тохижуулах ангид автобусыг 2021 онд хүлээлгэн өгсөн ба одоо хэвийн ашиглагдаж байна.	95.0
3.4.9	Ерөнхий зориулалтын бага оврын агаарын хөлгийн байнгын нислэг бий болгоно.	Орхон-Булган аймгийн иргэдийг хот хооронд зорчих нөхцөлөөр хангах санал хүсэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвөөс аймагт ерөнхий зориулалтын бага оврын агаарын хөлгийг 7 хоногт 1-2 удаа тогтмол үйлдэх чиглэлээр дүгнэлт гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлээд байна. 2023 онд аймгийн нисэх буудлаар аялал жуулчлалын зориулалтаар бага оврын онгоц 80 удаа хөөрч буух үйлчилгээг авсан байна.	30.0
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО			
4.1. "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ.			

4.1.1	"Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажил 2021 оноос хэрэгжин аймгийн хэмжээнд 16 сум, 9 байгууллагын 45 төрийн албан хаагч, 25 аж ахуйн нэгжид тоон гарын үсгийг нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлэн 2024 оны байдлаар 34307 иргэн, 16 сумын 345 аж ахуйн нэгж, байгууллага тоон гарын үсэгтэй болж, төрийн 800 гаруй үйлчилгээг тоон гарын үсэг ашиглан авах боломж бүрдсэн. 2021 онд төрийн үйлчилгээний "E-Mongolia" нэгдсэн системийг аймгийн хэмжээнд 16 суманд бүрэн нэвтрүүлснээр төрийн 23 байгууллагын 373.8 сая төгрөгийн бүрэн цахимжсан 217 үйлчилгээг 2081 иргэн авч үйлчлүүлээ. Хоёр шатлалт үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж сургалт, техникийн шинэчлэлтийг хийснээр орон нутгийн 9 байгууллагын 62 үйлчилгээг нэвтрүүлэн 2022 онд төрийн 27 байгууллагын 1.8 сая төгрөгийн 252 үйлчилгээг 1852 иргэн авч үйлчлүүлсэн байна. 2023 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын "Г" блокод Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс "ХУРДАН" төвийг байгуулж, техник тоног төхөөрөмжөөр хангаж, 4 шинэ ажлын байрыг бий болгосон. 2023 онд аймгийн 16 сум, 1 тосгон 3591 үйлчилгээ, Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс 2649, нийт 6240 үйлчилгээг 6240 иргэнд "E-Mongolia" цахим системээр үзүүлсэн нь аймгийн насанд хүрсэн хүн амын 15.3 хувийг эзэлж байна. 2023 онд "Цахим Булган" хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, "Смарт Булган" аппликэйшнийн хөгжүүлэлтийг илүү сайжруулахаар тусган ажиллаж байна. Нийгмийн халамжийн нэгдсэн систем (ehalamj.mn)-ийг 2020 онд нэвтрүүлэн халамжийн үйлчилгээг цахим системд шилжүүлснээр 2020-2023 онд нийгмийн халамжийн 16 хөтөлбөрийн 69 төрлийн 411 үйлчилгээг цахимаар үзүүлж, 83364 иргэнд 27.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, 21267 хүүхдэд 60.2 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгө олгогдсон. Нийгмийн даатгалын 32 төрлийн үйлчилгээнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллээ цахимаар харах, хяналт тавих, хэвлэн авах, нийгмийн даатгалын лавлагаа, тодорхойлолт авах, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, ажилгүйдлийн тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл гаргах, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан илгээх, тэтгэвэр тогтоолтын хяналтын хуудсыг авах (цахим тэтгэврийн дэвтэр) зэрэг 14 төрлийн үйлчилгээг 100 хувь бүрэн цахимжуулаад байна.	97.5
4.1.2	Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.	2020-2024 оны хооронд аймгийн вэб сайтыг бүрэн шинэчилж, сумдын вэб сайтыг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хийж эхэлснээр иргэд вэб сайтаар дамжуулан төрөөс гарч буй бодлого шийдвэрийн талаарх мэдээллийг цаг алдалгүй авч хэвшсэн бөгөөд цаг үеийн болон салбарын мэдээ мэдээлэл, хууль тогтоомжийг сурталчлан үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог ханган ажиллаж байна. Аймгийн вэб сайт (bulgan.gov.mn)-д эрүүл мэнд, соёл, спорт, гадаад харилцаа, боловсролын салбарын 2000 гаруй мэдээ, мэдээлэл, сурвалжлагыг олон нийтэд бэлтгэн хүргэж, давхардсан тоогоор 65729 иргэн хандаж мэдээлэл авсан байна. Аймгийн хэмжээнд 23 байгууллага, 12 сум, 1 тосгон 72.0 сая төгрөгөөр вэб сайттай болж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2023 онд орон нутгийн төсвийн 13.1 сая төгрөгөөр 2 сум, 1 агентлаг вэб сайттай болсон. Төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан 1 байгууллага, 4 сум вэб сайтаа шинэчлэх засварын ажил үргэлжилж байна.	90.0
4.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.			
4.2.1	Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эрх ашгийг дээдэлсэн зөв бодлогыг хэрэгжүүлнэ.	2021-2024 онд 45 захиргааны хэм хэмжээний акт гаргасан бөгөөд давхардсан тоогоор 18000 гаруй иргэдийн санал хүсэлтийг сум болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх иргэний танхим, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын цахим хуудсаар авсан. Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд онцгойлон анхаарч сум, байгууллагууд оны эхэнд "Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалт"-ыг батлан гаргаж иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд 120 гаруй төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 400 гаруй ажил арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээг зохион байгуулахад 32.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна.	100

4.2.2	Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	Аймагт дутагдалтай байгаа төрийн албан хаагчийг нөхөх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг 10 удаа, тусгай шалгалтыг 7 удаа зохион байгуулж, зарим орон тоог нөхсөнөөр төрийн албанд ажиллагсдын тоо суурь түвшнээс 1.4 хувиар нэмэгдлээ. Нээлттэй зарласан давхардсан тоогоор 1346 сул орон тоонд 1017 иргэн шалгалтад оролцож, шалгалтын дүнгээр 305 иргэнийг нэр дэвшүүлсний 91 хувь нь тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна. Төрийн албанд тогтвортой ажиллахад аймаг орон нутгаас анхаарч аймгийн ИТХ-аар 20-80 хувийн орон нутгийн нэмэгдэл болон нэг албан хаагчид өдрийн 5.0-15.0 мянган төгрөгийн унаа, хоолны мөнгө олгон ажиллаж байна. Хангал сум, Хялганат тосгон, Сайхан, Бүрэгхангай, Тэшиг, Булган суманд шинээр томилогдон ажиллаж байгаа 30 гаруй албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлсэн байна. 2020-2023 онд төрийн албаны ерөнхий шалгалтад 328 иргэн бүртгэгдэж, тусгай шалгалтад 246 албан хаагч оролцож, 305 албан хаагчийг шатлан дэвшүүлж, 328 иргэн нөөцөд бүртгэгдэж, 42 албан хаагч шилжин ажилласан байна. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 2020-2024 онд 129 албан хаагч хамрагдаж, гадаад сургалтад хамрагдалтын тоо өмнөх жилүүдээс өсөж БНСУ, ОХУ, БНХАУ, Тайвань зэрэг улсад 6 удаагийн сургалт, семинарт 30 төрийн албан хаагч хамрагдсан. Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг 2020 онд улсын төсвийн 799.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж 2022 онд ашиглалтад оруулж, Бугат сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барих ажлыг хуучин барилгад их засвар хийхээр төлөвлөж, 2023 оны орон нутгийн төсвийн 296.7 сая төгрөгөөр их засвар хийлээ. 2023 онд Бугат сумын ЗДТГ-ын барилгын их засварыг орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгөөр хийж, Гурванбулаг сумын ЗДТГ-ын барилгын засварт 50.0 сая төгрөгийг 2023 оны орон нутгийн төсөвт тусгасан боловч тендер шалгаруулалтад компани шалгараагүйн улмаас он дамжиж 2024 оны төсөвт шилжсэн. Мөн орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр Орхон, Хишиг-Өндөр, Рашаант, Сайхан, Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газрын барилгад урсгал засвар хийж, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулав. 2022-2023 онд орон нутгийн төсвийн 317.3 сая төгрөгөөр аймаг, сумын ЗДТГ-ын албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, сайжруулсан байна.	96.3
4.2.3	Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2020-2024 онд бичгээр болон цахимаар 673 өргөдөл ирснээс ЗГХЭГ-ын 11-11 төвд ирүүлсэн 252, мэйлээр болон бичгээр 421 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Өргөдөл хүсэлтийн дагуу эмчилгээний зардалд шаардлагатай, сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн, орон байр хүссэн, газар хүссэн, тив дэлхийн тэмцээнд оролцоход дэмжлэг хүссэн 153 иргэнд 320.9 сая төгрөгийн мөнгөн тусламж дэмжлэгийг үзүүлсэн байна. Цахим засаглал бодлогын хүрээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг цаг хугацаа орон зайнаас үл хамааран гаргах нөхцөл боломжийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газар, 8 сумын Засаг даргын Тамгын газар буюу 50.0 хувь нь, 15 агентлаг буюу 65.0 хувь нь байгууллагын албан ёсны вэб сайтаар өргөдөл гомдол хүлээж авах цэс бий болгосон.	70.0
4.2.4	Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төр иргэдийн энэ төрлийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	2021-2024 онд 16 сум, 1 тосгоны давхардсан тоогоор 2633 төрийн алба хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 1927 сурагч, Булган сумын 49 төрийн болон төрийн өмчит байгууллагын 1908 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүй, Авлигын тухай ойлголт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 41 удаагийн сургалт зохион байгуулж, Авлигатай тэмцэх төлөвлөгөөний хэрэгжилт тайлант онуудад 87.0-94.0 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн. Авлига, албан тушаалын гэмт хэрэг 2020 онд 0, 2021 онд 1, 2022 онд 3, 2024 онд 0 бүртгэгдсэн байна. 2021 онд Авлигатай тэмцэх газраас хийсэн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээгээр 71.5 хувьтайгаар 12 дугаар байрт эрэмбэлэгдсэн. 2022 оны аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээгээр 70.6 хувьтай үнэлэгдсэн. Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ хийлгэхээр "Хотуга" болон "Булганы өнгө" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, Булган сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газарт судалгааны ажил хийгдсэн. Судалгааны дүгнэлтийг үндэслэн тус 2 байгууллагад аймгийн Засаг даргын албан бичгээр ажлын чиглэл хүргүүлэв.	80.0
4.2.5	Аймгийн ЗДТГ-ын дэргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг шинээр байгуулна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Г блокыг "E-Mongolia" төрийн үйлчилгээний нэгдсэн төв болгох хүрээнд 247.6 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, 64.8 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв болох "ХУРДАН" төв 2 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.	100

4.2.6	MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо - шаардлагатай стандарт" төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.	"Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандарт"-ын мэдлэг олгох сургалтыг 16 сум, 1 тосгон, 22 төрийн байгууллагыг хамруулан зохион байгууллаа. Үе шаттайгаар зохион байгуулсан ажлын хүрээнд 2023 оны эцсийн байдлаар Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Тэшиг, Булган, Хангал, Хутаг-Өндөр сум Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015" стандартыг амжилттай нэвтрүүлж, сумын төсвөөс нийт 68.4 сая төгрөг зарцуулсан байна. "Дотоод аудитор бэлтгэх нь" сургалтыг жил бүрийн 6 дугаар сард зохион байгуулан төрийн албан хаагчдыг чадавхжуулж байна.	100
4.2.7	Уламжлалт харилцаат ОХУ, БНХАУ болон өндөр хөгжилтэй Япон, БНСУ, АНУ, БНТУ, БНБеларусь, Чех зэрэг улстай эдийн засгийн үр ашиг бүхий гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	ОХУ-ын Буриад улстай хамтын ажиллагааны хүрээнд тус улсын Тэргүүн А.С.Цыденов болон Засгийн газрын гишүүдтэй албан уулзалт хийж, олон улсын "Алтаргана 2024" наадмын зохион байгуулалт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсролын салбарын хамтын ажиллагааны хүрээнд нийт 5 удаагийн уулзалт, арга хэмжээнд хамтран ажиллаад байна. Оюутан, залуусыг гадаадын улс орнуудад суралцах, мэргэшүүлэх зорилт тавьж Буриад улсад малын эмчийн чиглэлээр 9 оюутныг 100 хувийн тэтгэлэгтэй, БНСУ-ын Кёэнги мужийн "Шинхан" их сургуультай хамтран аймгийн шилдэг 21 сурагчийг, БНБУ-ын Жодино хотын Техникийн коллежид 3 оюутан 100 хувийн тэтгэлгээр тус тус суралцаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр хэрэгжиж буй гадаадад хүний нөөцөө бэлтгэх төслийн хүрээнд 2023 оноос манай аймгаас 5 сурагч БНХАУ-ын ТОП сургуульд 100 хувийн тэтгэлэгтэйгээр суралцаж эхэллээ. 2023 онд БНСУ-ын "BOYS SCOUT", аймгийн скаутын холбоотой байнгын хамтын ажиллагаатай байхаар үзэглэв. БНСУ-ын Чангвон хотод дэлхийн 20 гаруй орон оролцсон "МАМФ" ОУ-ын фестивалд аймгийн соёл болон аялал жуулчлалыг 30000 гаруй гадны иргэдэд сурталчилж чадлаа. ЗХАНЗХ-ны 13 болон 14 дэх удаагийн Бүгд хуралд аймгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд Булган аймгаа төлөөлөн оролцсон. ЗХАНЗХ (NEAR)-ны байгууллагад Монгол улсыг төлөөлөн ТЗУХ-ийн мэргэжилтэн М.Энжаргал 1 жилийн хугацаатай ажиллаж байна. АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтын ажиллагааны хүрээнд тус Элчин сайдын яамны Иргэн цэргийн дэмжлэгийн бүлэг 2 удаагийн "Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нь" сэдэвт туршлага судлах, дадлагуулах сургалтыг зохион байгууллаа.	93.3
4.3. Хууль, эрх зүй, батлан хамгаалах. Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.			
4.3.1	Аймгийн төв болон сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	2021-2023 онд орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр аймгийн хяналтын камерын системийг шинэчлэх, өргөтгөх ажил хийгдэж, 38 цэгт 96 ширхэг хяналтын камертай болгон өргөтгөж, 3 цэгт дэд станцуудыг байршуулснаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хяналтын камерыг Цагдаагийн газрын серверт холбох бүрэн боломжтой болсон. 2024 онд төрийн болон хувийн хэвшлийн 6 байгууллагын 13 ширхэг хяналтын камерыг Цагдаагийн газрын серверт холбоод байна. 2021-2024 онд Бүрэгхангай, Орхон, Рашаант, Баян-Агт, Хангал сум, Хялганат тосгоны гудамж талбайд 61.7 сая төгрөгөөр хяналтын камер шинээр байршуулж, орон нутгийн төсвийн 15.0 сая төгрөгөөр 16 сумын цагдаагийн хэсгийн кобан байранд skyworth брэндийн 360 градус эргэдэг PTZ камер байршуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 2020-2023 онд 184 бүртгэгдсэн бөгөөд илрүүлэлт 2021 онд 54.6 хувь, 2022 онд 55.3 хувь, 2023 онд 56.1 хувьтай байна. Энэ нь 2023 онд 2020 оноос 6 гэмт хэргээр буюу 15.54 хувиар буурч, илрүүлэлт 3.9 пунктээр нэмэгдсэн дүнтэй байна. 2022 онд 467 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар, илрүүлэлт 55.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин 501 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 286 хүнээр буюу 36.3 хувиар буурчээ. 2023 онд Гэмт хэрэг, зөрчил, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах чиглэлээр аймгийн хэмжээнд Цагдаагийн газраас 8 нэгдсэн, 14 хэсэгчилсэн, 12 тусгай арга хэмжээг зохион байгуулж, 6 төрлийн видео, 18 төрлийн зурган постер мэдээллийг аймгийн олон хандагчтай 152 группт 17945 удаагийн түгээлтийг хийж, 57841 удаагийн хандалт авсан байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн "Сайхан Монгол" телевизийн "Хуульчийн цаг" нэвтрүүлэгт 6 удаагийн сэрэмжлүүлэг, ярилцлага мэдээлэл бэлтгэн 7 хоногт 3 удаагийн давтамжтайгаар иргэдэд хүргэсэн. 2024 онд "Цагаан сар", "Зэвсэг", "Эргүүл" зэрэг 1 нэгдсэн, 2 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулаад байна.	97.5

4.3.2	Мансууруулах бодис хэрэглэгч, архинд донтогчдод эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	"Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 32.0 сая төгрөг шийдвэрлэсэн. 2021-2023 онд сургалт, нөлөөллийн ажлыг олон хэлбэрээр зохион байгуулж 245 байгууллага, аж ахуйн нэгж, 2028 иргэнийг хамруулсан байна. Цагдаагийн байгууллагын "Судалгаа хяналтын сан"-д байнга архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэж болзошгүй 109 иргэний мэдээллийг оруулсан. 2022 онд аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 121 бүртгэгдэж 14 нэгжээр буюу 10.4 хувиар буурч, 2023 онд аймгийн хэмжээнд архианаас ангижрах 7 "АА" цуглаан зохион байгуулагдаж, жилийн эцсийн байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57 нэгжээр буюу 54.8 хувиар буурсан. Орон гэргүй болон байнга архины хамааралтай 15 иргэнийг албадан эмчилгээнд явуулсан бөгөөд хэрэгжилт 94.0 хувьтай байна. "Устгал" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг жил бүр гаргаж, арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс хамтран санхүүжүүлж сүүлийн 3 жилд 28.0 сая төгрөг зарцуулсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 2021 онд 1, 2022 онд 1, 2023 онд бүртгэгдээгүй болно.	100
4.3.3	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.	2021-2024 онд аймгийн хэмжээнд "Зөвийг хэвшүүлэе", "Яараад яахав дээ", "Уусан бол жолоо бүү барь", "Гэрлээ анхааруулъя", "Гар утас", "Сургууль орчмын бүс", "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ", "Хүүхдийн суудал", "Ядарсан үедээ жолоо бүү барь", "Дугуй", "Хамгаалалтын малгай" нөлөөллийн нэгдсэн арга хэмжээ, техник хяналтын чиглэлээр "Ачааны автомашины бүрэн бүтэн байдал", "Ачаа тээвэр", "Тээврийн хэрэгслийн өнгөт хальс-тень", "Арлын дугаар-2022", "Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал-Оношилгоо" зэрэг тусгай арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Ингэснээр хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2020 онд 28 бүртгэгдэж байсан бол 2023 оны жилийн эцсээр 25 бүртгэгдэж 10.8 хувиар энэ төрлийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна.	90.0
4.3.4	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	2021 онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бүх хайраа гэр бүлдээ" нөлөөллийн аяныг зохион байгуулж "Аялах дэвтэр"-ийн удирдамж, төлөвлөгөөг гарган байгууллагуудаар аялуулах, санамж хэвлүүлж тараах, насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхдийн өмнө үүрэг хүлээгч гишүүн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус онд хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт оруулах, хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдээгүй. 2022 онд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 16 сум, 1 тосгоны 446 хүүхэд, 280 иргэнээс тоон судалгаа, 297 хүүхэдтэй бүлгийн ярилцлага зохион байгуулж, чанарын судалгаа авсан. Судалгааны үр дүнг нэгтгэн сумын Засаг дарга болон хүүхдийн төлөө зөвлөлийн даргад зөвлөмж хүргүүлэн 1761 хүүхэд үе тэнгийн дээрэлхэлт, эерэг хандлага, 220 багшид "Багшийн ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 2023 онд орон нутгийн төсвийн 8.0 сая төгрөгөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 7-30 хоног баривчлах шийтгэлтэй 186 иргэнд "Гэрэлт Ирээдүй" төрийн бус байгууллагатай хамтран "Гэр бүлийн үнэ цэнэ", "Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог", "Харилцаа хандлага" зэрэг 16 удаагийн сургалт, "Бялхам үндэс" ТББ-тай хамтран амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой архины хамааралтай 8 эмэгтэйг оёдол, эсгүүрийн сургалтад 30 хоног хамруулж, ерөнхий боловсролын 22 сургуулийн "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн 168 гишүүнд "Гэмт хэрэг, зөрчлийг мэдээллэх нь", "Үе тэнгийн дээрхэлтээс ангид байя", "Хорт зуршил" зэрэг сэдвээр 6 удаагийн сургалт хийлээ. Гэмт хэргийн улмаас 2021-2023 онд 91 хүүхэд хохирсон бол хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2020 онд 19, 2021 онд 19, 2022 онд 29, 2023 онд 15 бүртгэгдэж, 2023 оныг 2020 онтой харьцуулбал 4 гэмт хэргээр буюу 21.1 хувиар буурсан. Хүн худалдаалах гэмт хэрэг тайлант онуудад бүртгэгдээгүй байна.	90.0
4.3.5	Баривчлах байрыг стандартын шаардлагад нийцүүлнэ.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь баривчлах шийтгэл эдлүүлэх үйл ажиллагааг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба тус ажлын хүрээнд цагдан хорих байрны 26 хүний багтаамжтай 1-5 дугаар өрөө болон коридорт иж бүрэн засвар үйлчилгээ хийж, стандарт шаардлагад нийцүүлээд байна.	100
4.3.6	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.	Төрийн Архивын тасагт төрийн байгууллагын газар эзэмших эрхийн бүртгэлийн Э-0405000803 дугаарт бүртгэл бүхий 000011712 дугаартай гэрчилгээ 2021 онд олгогдсон. 2022 онд Архивын тасгийн барилгын зураг төслийн ажлыг "ОСИБ" ХХК 58.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Төрийн Архивын тасгийн барилгыг бариулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.	50.0

4.3.7	Хуулийн салбарын байгууллагуудын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилж, ажиллах орчныг сайжруулан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021-2023 онд улсын болон орон нутгийн төсвийн 314.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуулийн салбарын байгууллагуудад 4 автомашин, 3 мотоцикл, 1 автобус шинээр худалдан авч, 7 автомашин засварласан. Аймагт томилогдон ажиллаж байгаа Шүүхийн шинжилгээний албаны кримналистикийн шинжээч болон шинжээч эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулж аймгийн төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 ерөө байр худалдан авч, орон сууцыг албаны хэрэгцээнд ашиглаж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хаалттай 439 дүгээр хорих ангийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор спорт заал барих ажлыг батлагдсан төсвийн хүрээнд 2021-2023 онд 1215.7 сая төгрөгийн санхүүжилтийг сайдын багцад тусгуулан спорт заалыг бариулж 2023 оны 12 дугаар сард улсын комисс ашиглалтад хүлээн авсан. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газраас 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хорих ангийн эмнэлгийг нэн шаардлагатай 28 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангасан. Мөн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст цахим төлбөрийн систем буюу "ГЭРЭГЭ КИОСК" төхөөрөмжийн 5.0 төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэн үйлчилгээний танхимд байршуулж, иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэв. 2023 оны байдлаар 15000 гаруй иргэн цахим машинаар үйлчилгээний хөлс тушаасан байна.	100
4.3.8	Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр хөтөлбөр батлуулан хэрэгжүүлнэ.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийн 2 дугаар үе шатыг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр батлуулж, 3 жилийн хугацаанд 39.0 сая төгрөгийг зарцуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021, 2022 онд 100 хувь, 2023 онд 95.7 хувьтай биелүүлэн ажиллалаа. Хөтөлбөрийн үр дүнд хөдөөгийн алслагдсан 37 багийн 7025 малчин өрхөд эрх зүйн багийн үйлчилгээг үзүүлсэн. Мөн 16 сум, 1 тосгоны 5788 хүүхэд, 4892 ахмад настан, 1986 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, давхардсан тоогоор 12827 иргэн, төрийн алба хаагч нарт эрх зүйн багаар дамжуулан эрх зүйн сургалт зохион байгуулан 10000 гаруй гарын авлага, тараах материал хүргэжээ. Эрх зүйн хөтөч буланд 379 төрлийн хууль, эрх зүйн мэдээллийг байршуулан давхардсан тоогоор 3401 иргэн үзсэн байна. Эрх зүйн хөтөч нарын шинээр мөрдөгдөж буй хуулиудаар бэлтгэсэн 3115 ширхэг гарын авлага, хууль хяналтын байгууллагуудын эрх зүйн 2401 ширхэг зөвлөмж, материалыг 2982 малчинд хүргэсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласнаар иргэдийн хууль эрх зүйн боловсрол нэмэгдэж, аймгийн эрүү, иргэний хэргийн болон эвлэрүүлэн зуучлахаар зөрчигдсөн эрхээ шийдвэрлүүлэх зорилгоор 2023 онд 3411 иргэн хандаж үйлчлүүлсэн нь 2021 оноос 94.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
4.3.9	Аймаг, сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаа, хийж, гамшиг аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, техник тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.	2021-2023 онд аймгийн 16 суманд гамшгаас хамгаалах болон команд штабын сургууль зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөний дагуу бүрэн зохион байгуулсан. Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Бугат, Хангал сум, Хялганат тосгоны ЕБС, цэцэрлэгүүд, Булган сумын МСҮТ, Хөдөө аж ахуйн МСҮТ, "Эрдмийн-Өргөө" цогцолбор сургууль, Спортын дунд сургуульд эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, объект дээр орон нутгийн удирдлага, баг, иргэдийн төлөөлөлтэй хамтран үнэлж зөвлөмж гарган улсын онц чухал, галын онц аюултай шатахуун түгээх станц, уул уурхайн компаниудад нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийгдэж байна. 2022 онд 56, 2023 онд 18 төрийн болон цэрэг, хууль хяналтын байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгийн эрсдэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг хангуулж хамтран ажилласан. 2021-2023 онд 16 сум, 1 тосгоны хэмжээнд гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд хөдөлмөр хамгааллын хувцас, багаж худалдан авах, гамшгаас хамгаалах сургууль, дадлага зохион байгуулах зэрэгт 484.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар Хангал сумын Хялганат тосгон дахь Гал түймэр унтраах, аврах 50 дугаар ангийн шинэ барилга, алба хаагчдын орон сууцны барилгын засварын ажил хийгдэж, 2024 онд ашиглалтад өгөхөөр ажиллаж байна.	100
4.3.10	Хутаг-Өндөр суманд эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, бэлэн байдлыг хангана.	Засгийн газрын тогтоолын дагуу Хутаг-Өндөр суманд эрэн хайх, аврах салбар байгуулах шийдвэр гарч Онцгой байдлын ерөнхий газраас 60.0 сая төгрөг, Хутаг-Өндөр сум, орон нутгийн хөгжлийн сангаас 30.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн барилга байгууламжийн засвар, тавиулан парк шинээр барьж ашиглалтад өгч 2022 оны 10 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2023 онд аймгийн орон нутгийн санхүүжилтээр шуурхай дуудлагын автомашинаар парк шинэчлэлт хийгдэж, гадна талын хашаа, дотор засварын ажлыг хийв. Тус аврах бүлэг үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хойд бүсийн сумдад гамшиг, аюулт үзэгдэл осол гарсан үед төрийн үйлчилгээг шуурхай үзүүлж, иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах, эрсдэл хохирлыг бууруулах арга хэмжээг хугацаа алдалгүй шийдвэрлэн ажиллаж байна.	100

4.3.11	Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2021-2023 онд Бүрэгхангай, Могод, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон багийн Засаг дарга нар, нийт 150 хүн хамрагдав. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г орон нутагт хэрэгжүүлж жилд 3-аас доошгүй арга хэмжээг төлөвлөн зохион байгуулсан. Жил бүр Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан даалгаврын дагуу "Монгол цэрэг-дэлхийн цэрэг" сэдэвт сурталчилгааны ажлыг Булган сумын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад зориулан хийж хэвшив. Аймгийн хэмжээнд батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж тус үйл ажиллагаанд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагууд, ҮБХИС, ЦДБЭЧ, Алдар спорт хороо, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, "Соёмбо" редакц, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид, Зэвсэгт хүчний 015, 032, 084, 110, 186, 234 дүгээр анги, Зэвсэгт хүчний үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба зэрэг 430 хүний бие бүрэлдэхүүн оролцлоо. "Оюутан-цэрэг" сургалтад 2021-2024 онд 30 оюутан, сурагч хамрагдаж, цэргийн албыг хаагаад байна. АЗДТГ-ын 5 давхарт цэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын танхим байгуулан шинээр 20 ширээ, 40 сандал авч, цэргийн сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэн тохижуулж, сургалтууд явуулж байна. 2022 онд аймгийн хэмжээнд "Монгол цэрэг-Монгол морь" аяныг зохион байгуулж, 16 сумын иргэдээс 68 агт Хилийн цэргийн 0286 дугаар ангид хандивлав. 2023 онд улсын хилийн зурвас газрын эргэлтийн цэгт анхааруулах самбар хийхэд шаардлагатай 5.0 сая төгрөгийг шийдвэрлэж, 11 ширхэг тэмдэг, тэмдэглэгээ, 3 ширхэг анхааруулах самбар хийж байршууллаа.	84.0
--------	---	---	------

ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

5.1.1	Булган, Орхон суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулна.	Булган сумын 1 дүгээр баг Байгаль орчин-4 гудамж 410 тоот байршилтай газарт "Дэвших конкрет" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад орж, 540 гаруй тн зуурмаг орон нутгийн барилга бүтээн байгуулалтын ажилд нийлүүлсэн байна. Тус үйлдвэрийн газар нь Орхон сумын нутагт хайрга дайрганы хайгуулын зөвшөөрөл авч, орон нутгийн бүтээн байгуулалтад зуурмаг нийлүүлэн ажиллаж байна.	100
5.1.2	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын төлөвлөгөөнд манай аймагт БНХАУ-ын 19.5 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор" барьж байгуулахаар тусгаж, Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсгэт 91302 м.кв талбай бүхий газрыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн боловч төсөл хэт өндөр төсөвтэй гэсэн шалтгаанаар цуцлагдсан. Тус бүсэд Булган сумын "Бүрэн луу" ХХК мал мах бэлтгэлийн цехийн үйлдвэрлэлийн дамжлагад шаардлагатай 4x6 хэмжээтэй гүн хөлдөлтийн, 9x11 хэмжээтэй махны хөргөлтийн агуулах шинээр байгуулав. Манай аймаг 1.7 сая толгой хонин сүргээс жилд 2.04 мянган тн ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрүүдэд 1.2 мянган тн ноос бэлтгэн нийлүүлж, 4200 малчин өрх ноосны урамшуулалд хамрагдаж байна. Хутаг-Өндөр сумын "Занаду розарбак" ХХК 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мал нядалгааны цэг, ангилан ялгах үйлдвэр, Бүрэгхангай сум орон нутгийн хөгжлийн сангийн 170.0 сая төгрөгөөр мал нядалгааны цэг байгуулав. Хангал суманд "Хялганат эко мах" ХХК хоногт 50 бод, 200 бог мал нядлах хүчин чадалтай, 50 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулах бүхий үйлдвэр ашиглалтад орууллаа. "Булган мах маркет" ХХК Иран улсад 370 тн мах экспортод нийлүүлж, БНХАУ-д мах экспортлох зөвшөөрөл авч, улсын нөөцөд 50 тн мах бэлтгэж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас "Буман сүхэс" ХХК-д хиам лаазалсан мах үйлдвэрлэх тоног төхөөрөмж авах төсөлд 60.0 сая төгрөг, Баянцөнгөрөг хоршоонд хөргүүртэй махны агуулах барих төсөлд 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр төслүүд амжилттай хэрэгжиж байна. Булган аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зориулалт бүхий худалдааны дундын бүсийг Орхон сумын Халиун багт төлөвлөж, 2023 оны улсын төсөвт 350.0 сая төгрөг тусгуулж, зураг төсвийг боловсруулж байна. Булган, Орхон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чөлөөт худалдаа хийгдэж, Булган, Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх, сурталчлах зорилгоор хөрш зэргэлдээ аймгууд Дархан-Уул аймаг болон улсын "Өвлийн идэш", "Цагаан сар", "Алтан намар", Намрын ногоон өдрүүд, Айрагны баяр зэрэг үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгч, малчид, иргэдийг зохион байгуулан оролцуулж хэвшээд байна.	70.0

5.1.3	Өрхийн орлогод нийцсэн, амины, түрээсийн гэх мэт инженерийн шийдэл бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, Булган суманд 150, сумдад 50-аас доошгүй айлын орон сууц барина.	Булган сумын 5 дугаар баг 186 байрны урд "Биг эко" ХХК-ийн захиалгаар 2 блок 84 айлын орон сууцны барилгын эхний 1 дүгээр блокны суурийн ажил 2021 онд хийгдсэн. Булган сумын 5 дугаар багт "Булган өргөө" хотхоны 2 дугаар блок 28 айлын орон сууцыг "Их азар" ХХК барьж 2022 онд, Булган сумын 2 дугаар баг "Нарлаг өргөө" хотхоны баруун талд 25 айлын орон сууцыг "Их-Ураг" ХХК 2023 онд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдын 8 айлын орон сууцны барилгыг "Хурмастын хүлэг" ХХК өөрийн хөрөнгөөр хөнгөлөлттэй нөхцөлөөр барьж 2023 онд, Булган сумын 6 дугаар багт "Их ураг" ХХК үйлчилгээ бүхий 25 айлын орон сууцны барилгыг барьж тус тус ашиглалтад оруулаад байна. 2023 онд Булган сумын 5 дугаар багт Иргэн Ш.Баттөр хувийн хөрөнгө оруулалтаар 56 айлын орон сууцны барилга барьж байгаа бөгөөд 2024 онд ашиглалтад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. "Нүнжиг өргөө" ХХК өөрийн хөрөнгөөр 25 айлын нийтийн орон сууцны барилга барьж байгаа бөгөөд 2024 оны 4 дүгээр улиралд, Булган сумын 6 дугаар багт "Их ураг" ХХК өөрийн хөрөнгөөр үйлчилгээ бүхий 25 айлын орон сууцны 2 дахь блокын барилгыг 2024 оны 3 дугаар улиралд, Булган сумын 2 дугаар багт "Хурмастын хүлэг" ХХК хувийн хөрөнгө оруулалтаар 25 айлын 5 давхар нийтийн орон сууцны барилгыг 2024 оны 3 дугаар улиралд тус тус ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тэшиг суманд 2 айлын орон сууцыг орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр 2022 онд ашиглалтад оруулсан бол 2023 онд Хутаг-Өндөр сумын төвд 2 айлын орон сууцны барилгыг орон нутгийн төсвийн 110.0 сая төгрөгөөр "Бугат ариг" ХХК гүйцэтгэсэн. Хангал сумын Хялганат тосгоны төрийн албан хаагчдын 6 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг 420.0 сая төгрөгөөр "Эрдэнэс эко-үүр" ХХК гэрээ байгуулан, барилга угсралтын ажлыг 2023 онд ашиглалтад оруулав. Сайхан сумын төвд төрийн албан хаагчийн 4 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг орон нутгийн төсвийн 280.0 сая төгрөгөөр "Баганадант" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2024 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд нийтийн орон сууц барихаар төлөвлөгдсөн газруудад инженерийн шугам сүлжээ татахаар 1.5 тэрбум төгрөг тусгагдсан ба гүйцэтгэгчээр "Эрч арвин" ХХК шалгарч Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумын шугам сүлжээг ашиглалтад оруулсан.	80.0
5.1.4	Булган сум, хөдөөгийн сумын төв суурин газруудын үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Булган сумын үерийн байгууламжийн нэгдсэн зураг төслийг 2016 онд "Гидро сооружение" ХХК боловсруулж, байгууламжийн 80.0 хувийг 2016-2021 онд гүйцэтгэсэн. Булган сумын 6 дугаар баг, Хужир толгойн үерийн сувгийн ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт хүргүүлээд байна. 2023 онд Булган сумын "Миний голомт" дэлгүүрийн уулзвараас Онцгой байдлын газар хүртэлх үерийн сувгийг засварлах зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Хутаг-Өндөр сумын төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Хангилцаг" ХХК шалгаран 4279.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан 2022 онд ажлыг эхлүүлсэн. 2023 онд улсын төсвөөс 2000.0 сая төгрөгийн санхүүжилт авч С-3, С-4 суваг, ус тосох байгууламжийн ажлыг гүйцэтгэж, 11 дүгээр сарын 7-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Сайхан сумын төвийн үерийн хамгаалалтын далангийн ажлын гүйцэтгэгчээр "Хайдро проект" ХХК шалгаран 2020 онд 426.7 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж байх үед үер буусны улмаас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орж, Барилга, хот байгуулалтын яаманд нэмэлт санхүүжилтийн асуудлаар хандсан бөгөөд тус яамнаас нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, орон нутагт эрхийг шилжүүлснээр "Хайдро проект" компани үргэлжлүүлэн гүйцэтгэхээр нэмэлт гэрээ байгуулан ажил эхэлсэн боловч мөн 2022 оны 7, 8 дугаар сард орсон аадар борооны улмаас дахин үер бууж суваг эвдэгдсэн. Улсын хэмжээнд цементний хомсдол үнийн хөөрөгдлөөс шалтгаалж ажил 2023 онд үргэлжлэхээр болж дахин он дамнасан боловч үлдэгдэл хөрөнгө татагдаж, 2024 онд үлдэгдэл 80.0 сая төгрөг Барилга, хот байгуулалтын сайдын багцад тусгагдсан.	80.0

5.1.5	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлнэ.	<p>Азийн хөгжлийн банкны 1.45 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр Булган суманд шинээр 6 дугаар Ус дулаан дамжуулах төв түүний 1, 2 дугаар хэлхээний дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугамын угсралт, Булган сумын 5 ба 7 дугаар УДДТ-ийн барилга, түүний 1 ба 2 дугаар хэлхээний шугамын угсралтын ажлыг орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгөөр тус тус гүйцэтгүүлж 2021 онд ашиглалтад хүлээн авав. Мөн 4 дүгээр УДДТ-өөс Ус цаг уур, орчны шинжилгээний төв, "Дэлгэрэх өргөө" 35 айлын орон сууц хүртэлх дулааны 5 хос шугамын угсралтын ажлыг "Марвелхаус констракшн" ХХК орон нутгийн төсвийн 318.8 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Сэлэнгэ сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн системийн угсралтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр "Долоон бар" ХХК 2021-2022 онд гүйцэтгэж, 2022 онд ашиглалтад оруулав. 2021 онд Баян-Агт сумын цэвэр усны даралтад цамхаг шугамын ажлыг байгаль хамгаалах сангийн 291.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Хөх тавилан" ХХК хийж гүйцэтгэсэн. Сайхан сумын цэвэр усны шугамын 700 м, Ф100 мм-ийн шугам, 1 ширхэг ундны ус түгээх ухаалаг худаг угсрах ажлыг орон нутгийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Тэнгэр хишиг" ХХК гүйцэтгэж 2022 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн. Бүрэгхангай сумын цэвэр усны даралтад цамхаг барих 2 дугаар шатны ажилд 2022 онд 400.0 сая төгрөг тусгагдан "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулав. Орхон сумын цэвэр усны даралтад цамхагийн 2 дугаар шатны ажилд 2022 онд 200.0 сая төгрөг тусган "Сайхан хульж" ХХК 90.0 хувийн гүйцэтгэлтэй хийж байна. 2023 онд Хангал, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ сумын 2 дугаар шатны усан сангаар төвлөрсөн системд холбох шугамын ажлыг аймгийн орон нутгийн төсвийн 989.0 сая төгрөгөөр хийж дууслаа. Сэлэнгэ сумын төвийн цэвэр усан сангийн даралтат цамхагийг шинээр барихаар аймгийн байгаль хамгаалах сангаас 149.0 сая төгрөг тусгаж, ажлын гүйцэтгэгчээр "Баатар шүтээн уул" ХХК шалгаран гэрээ байгуулаад байна. 2024 онд Хангал сумын цэвэр усны 3 дугаар шатны ажилд 300.0 сая , Сэлэнгэ сумын төвийн цэвэр усны шугамын ажил 1470.0 сая, Хангал сумын Хялганат тосгоны инженерийн шугам сүлжээний өргөтгөл 335.0 сая, Сайхан сумын цэвэр усны 4 дүгээр шатны ажилд 550.0 сая, Баян-Агт сумын ариутгах татуургын шугамын өргөтгөл 282.0 сая, Сайхан сумын төвийн ариутгах татуургын шугамын өргөтгөл 292.0 сая, Бүрэгхангай сумын дулаан хангамжийн угсралтын ажилд 70.0 сая төгрөг тус тус тусгагдаж, тендер зарлах бэлтгэл ажлыг хангаж байна. Баян-Агт суманд орон нутгийн төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 970 м, Ф200 мм-ийн ариутгах татуургын шугам сүлжээ, 35 м.куб/хоног хүчин чадалтай сефтик цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэж 2021-2022 онд байнгын ашиглалтад оруулсан. 2021 онд Баян-Агт сумын цэвэр усны даралтад цамхаг шугамын ажлыг байгаль хамгаалах сангийн 291.0 сая төгрөгийн санхүүжилтээр, 2022 онд Сайхан сумын цэвэр усны шугамын 700 м, Ф100 мм-ийн шугам, 1 ширхэг ундны ус түгээх ухаалаг худаг угсрах ажлыг орон нутгийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2022 онд Сайхан сумын төвд хоногт 50 м.куб ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг 691.0 сая төгрөгөөр, 2023 онд Булган сумын 6 дугаар баг Д хэсэгт амины орон сууцны гадна дулаан, цэвэр хэрэглээний халуун ус, ариутгах татуургын шугамын ажлыг 600.0 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлээд байна.</p>	95.0
5.1.6	Авто зам, замын байгууламжийг өргөтгөж, Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км, Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 53.6 км хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулна.	<p>Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто замын ажлын үргэлжлэл 31.8 км хатуу хучилттай авто замыг "Рэс" ХХК 2022 оноос гүйцэтгэж эхэлсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яамтай 29880.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Замын ажлын явц 34 хувьтай үргэлжилж байна. Хишиг-Өндөр сумаас Гурванбулаг сум хүртэлх 67.8 км үлдэгдэл хатуу хучилттай авто замын ажилд 2024 оны улсын төсөвт 43.6 тэрбум төгрөг төлөвлөгдсөн. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажил нийт 4 багц бөгөөд Хялганат тосгоны Сэлэнгэ голын гүүрнээс Хангал сумын гүүр хүртэлх 23.6 км авто замыг "Замын бетум" ХХК, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын "Сэлэнгэ" амралт болон "Олимп" амралт хүртэлх 10 км зам, мөн гүүр далангийн ажлыг "Жавхланта харгуй" ХХК, Хангал сумын гүүрнээс Орхон аймгийн 3 замын уулзвар хүртэлх 30 км авто замын ажлыг "Хурдны зам" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Хялганат доторх 10.4 км авто замыг "Увт инвест" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2 удаа улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад ороогүй байна.</p>	80.0

5.1.7	Багийн төвүүдийг үүрэн телефон сүлжээнд хамруулж, нутаг дэвсгэрийн хэмжээгээр үүрэн холбоо, өндөр хурдны интернет ашилах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 онд үүрэн холбооны үндэсний оператор "Мобиком" ХХК 9 сумын 19 байршилд үүрэн холбооны сүлжээг шинээр суурилуулсан. "Юнител" компани 2022 онд Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 14 багийг шинээр сүлжээнд холбосон. Мөн Булган сумын 6Д хороолол болон 3 дугаар баг, "Жаргалант" зуслан гэсэн 3 газарт шинээр цамхаг босгож, сүлжээний өргөтгөл хийв. "Мобиком" компани Орхон сумын Халиун, Сайхан сумын Угалз, Ундрах багт шинээр сүлжээний цамхаг босгон ашиглалтад оруулснаар 20 байршил үүрэн холбооны сүлжээнд холбогдов. Бугат, Дашинчилэн, Могод, Сайхан, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 11 байршилд үүрэн холбооны сүлжээний антен байршуулах зориулалтаар газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгаж, газар олголтыг хийсэн ба Сайхан сумын 6 дугаар баг Эрээний уурхайн орчим Эрээн уулын урд үзүүрт үүрэн холбооны "Юнител" ХХК антен байршуулж, ашиглалтад оруулсан. 2021-2023 онд 40 байршилд үүрэн холбооны антен барьж ашиглалтад оруулан алслагдсан багийн иргэдийг төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлэв.	90.0
5.1.8	Цахилгаан, эрчим хүчний хангамжийг сайжруулж, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.	Баяннуур суманд орон нутгийн төсвийн 257.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Цац эрчис" ХХК Өлзийт багт 167 ширхэг төмөр бетонон тулгууртай СИП кабель ашиглалтад орууллаа. Мөн гэр хорооллын хүчдэлийг сайжруулах үүднээс 10/04 кВт-ын дэд станц шинээр барьж, ашиглалтад оруулсан. Хишиг-Өндөр сумын төвийн 04 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгуур СИП кабелиар шинэчлэх 3 үе шаттай ажил хийгдэж, 2023 онд сүүлийн 2 станцыг сольж, бүх станцууд бүрэн шинэчлэгдсэн. Дэлхийн банкны төслөөр ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд төмөр бетон тулгуур, 0.4 кВт-ын 7 км кабель, 10 кВт-ын 2 км кабель болон 400 кВт, 250 кВт, 160 кВт-ын 8 дэд станцын ажил 2022 онд хийгдэж, 3715 айл өрхөд 2 тарифт тоолуур суурилуулав.	100
5.1.9	Цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийж, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 онд "Ногоон шувууд" төрийн бус байгууллага ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор Рашаант, Хутаг-Өндөр, Бүрэгхангай сум болон Хялганат тосгонд мод тарих газрын хөрсний дээжийг шинжилсэн. 2022-2023 онд Дашинчилэн, Рашаант, Баяннуур суманд элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор 9 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг "Хөвөнтөн ой" ХХК, "Газар зүй геоэкологийн хүрээлэн" шалгарч 6000 ширхэг мод тарьснаас 5236 ширхэг мод ургаж, нөхөн тарилт хийлгэж амьдралын 90.7 хувьтай аймгийн комисс хүлээн авсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант суманд элсний нүүдлийг сааруулах механик хаалт 8 га талбайд хийх ажлын гүйцэтгэгчээр "Есөн мөнх сүлд" ХХК 71.5 сая төгрөгөөр шалгарч, торон хашаа барих ажлыг хийж гүйцэтгэв. Мөн сүрлээр механик ажил хийж гүйцэтгэсэн. 2024 онд цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажлыг 12 га талбайд 4 суманд хийгдэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд 180.0 сая төгрөг батлууллаа. Орон нутгийн төсвийн 192.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн 120.0 мянган га талбайд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 70 мянган га талбайд энгийн механик, биологийн аргаар бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, жил бүр тархалтыг нэмэгдүүлэхгүй байхад анхааран ажиллаж байна.	100
5.1.10	Орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжинэ.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны XIII/03 дугаар тогтоолоор "Нээлттэй Булган" хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд 6 зорилтыг хэрэгжүүлж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 90.0 хувьтай байна. НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран "Монгол дахь дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь" сургалтыг зохион байгуулж, бодлого боловсруулагч, шийдвэр гаргах түвшний 53 албан хаагч хамрагдлаа. Мөн "Хөдөөгийн сэргэлт" үндэсний чуулганд оролцож, "Мэдээллийн ТҮЦ" ажиллуулан 1400 орчим иргэдэд мэдээлэл өгч аймаг, орон нутгийн онцлогоо сурталчлан ажиллав. Нээлттэй аймаг хөтөлбөрийн хүрээнд "Нээлттэй Булган" өдөрлөг, орон нутгийн түвшинд хөрөнгө оруулалтыг татах зөвлөлдөх уулзалт, "Хөдөөгийн сэргэлт-Хөрөнгө оруулагчдын чуулган" зэргийг зохион байгуулсан. Дээрх ажлуудад орон нутгийн төсвөөс 41.7 сая төгрөг зарцуулжээ. Албан ёсны вэб сайт болон шилжилт хөдөлгөөн хариуцсан ажилтан томилон 7034-2441 дугаарын утсаар холбогдох мэдээллийг хүргэж байгаа бөгөөд сумдад ажиллаж амьдрах хүсэлтэй байгаа иргэнд оршин суух газар болон ажилд оруулах талаарх мэдээллээр бүрэн хангаж суурьшуулаад байна. 2023 онд аймагт 924 хүн шилжин ирсний 33.3 хувь нь Улаанбаатар хотоос ирсэн байна. 2023 онд 72 аж ахуйн нэгж шинээр байгуулагдаж, 4 аж ахуйн нэгж Улаанбаатар хотоос манай аймагт шилжин ирж үйл ажиллагаагаа явуулж байна.	90.0